

**СОНГОЛТ ДИЗАЙН ХХК**

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЧОЙР ХОТЫН ХӨГЖЛИЙН  
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ**

**БОТЬ - I**

ТАЙЛБАР БИЧИГ  
2024 ОН



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЧОЙР ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТОДОТГОЛ

ТАЙЛБАР БИЧИГ

- ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Шифр: SDC23-01/03



ГҮЙЦЭТГЭГЧ

"СОНГОЛТ ДИЗАЙН" ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... /Я. СУМХҮҮ/



ЗАХИАЛАГЧ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Улаанбаатар хот

2024 он

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЧОЙР ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛЫН ЗОХИОГЧДЫН БАГ БҮРЭЛДЭХҮҮН**

Нэр	Мэргэжил	Гүйцэтгэсэн ажил	Гарын үсэг, тамга
Я.Сумхүү	Хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор, Хот төлөвлөлтийн магистр	Төслийн удирдан зохион байгуулалт	 МОНГОЛ УЛС 21042-1 АТХ6809 Я.СҮМХҮҮ 13РГЭСЭН АРХИТЕКТОР 2021-2024
Б.Бямбажав	Монгол Улсын зөвлөх инженер, Ус хангамж, ариутгах татуургын магистр	Ус хангамж, ариутгах татуургын одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС CONSULTING ENGINEER BAMBAYAY Batsukh 14-25 08-678-1111 2021-2024
П.Энхбаатар	Монгол Улсын зөвлөх архитектор	Архитектур орон зайн төлөвлөлт, гудамж зам тээврийн сүлжээ	 МОНГОЛ УЛС ЗӨВЛӨХ АРХИТЕКТОР CONSULTING ENGINEER PUREV 2021-2024
Б.Пүрэвээ	Монгол Улсын зөвлөх инженер	Дулаан хангамжийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
П.Түвшинжаргал	Хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор	Архитектур орон зайн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт, гудамж зам тээврийн сүлжээ	 МОНГОЛ УЛС 2021-2024
М.Шинэтөр	Хот төлөвлөлтийн мэргэшсэн эдийн засагч	Нийгэм, эдийн засгийн судалгаа, төлөвлөлт, тооцоо, тайлбар бичиг	 МОНГОЛ УЛС 2021-2024
С.Пүрэвсүрэн	Архитектор	Архитектур орон зайн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
Ч.Мандухай	Архитектор	3D Харагдах байдал, Дизайн	 Ч. Мандухай
Б. Марал	Хот ба бүс нутаг төлөвлөгч	Газар ашиглалт, Газар зохион байгуулалт	 Б. Марал
Б.Шинэбаяр	Дулаан хангамжийн инженер	Дулаан хангамжийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
Б.Молом	Ус хангамжийн мэргэшсэн инженер, ариутгах татуургын магистр	Ус хангамж, ариутгах татуургын одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
Д.Дондогмаа	Мэдээлэл, холбоо, дохиололын мэргэшсэн инженер	Мэдээлэл, холбооны сүлжээний одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
Д.Даваажаргал	Мэргэшсэн инженер, Техникийн ухааны магистр	Өндөржилт, улаан шугам төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
П.Саруул	Усны барилга байгууламжийн мэргэшсэн инженер	Инженерийн бэлтгэл арга хэмжээний одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
М.Оргил	Цахилгааны мэргэшсэн инженер	Цахилгаан хангамжийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт	 МОНГОЛ УЛС 2021-2024
Туслан гүйцэтгэгч	Геомеп ХХК	Геодезийн байрзүйн зураг	

**ГАРЧИГ**

<b>1</b>	<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАСАГ ЗАХИРГАА, ГАЗАРЗҮЙ, БАЙГАЛЬ ОРЧИН</b>	<b>12</b>
1.1	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ	12
1.2	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УУР АМЬСГАЛ	12
<b>2</b>	<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ</b>	<b>17</b>
2.1	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ	17
2.2	УУЛ УУРХАЙ	17
2.3	ТЭЭВЭР ЛОЖИСТИК	18
2.4	ХӨДӨӨ АЖ АХУЙ	19
2.5	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	20
<b>3</b>	<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЧОЙР ХОТЫН ОДООГИЙН БАЙДАЛ</b>	<b>21</b>
3.1	ИНЖЕНЕР ГЕОЛОГИ ДҮГНЭЛТ	22
3.2	ЧОЙР ХОТЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ	25
3.2.1	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	25
3.2.2	ХҮН АМ	26
3.3	ХӨДӨӨ АЖ АХУЙ	28
<b>4</b>	<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАРИЛГАЖИЛТ, ГАЗАР АШИГЛАЛТ, ЗАМ ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭНИЙ ОДООГИЙН БАЙДАЛ</b>	<b>30</b>
4.1	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГАЖИЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ	30
4.2	ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ	33
4.3	НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГАЖИЛТИЙН ОДООГИЙН БАЙДАЛ	35
4.4	ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ	45
4.5	ГУДАМЖ, ЗАМ, ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭНИЙ ОДООГИЙН БАЙДАЛ	53
<b>5</b>	<b>ТАВДУГААР БҮЛЭГ. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ОДООГИЙН БАЙДАЛ</b>	<b>56</b>
5.1	ДУЛААН ХАНГАМЖИЙН ОДООГИЙН БАЙДАЛ	56
5.2	УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ОДООГИЙН БАЙДАЛ	72
5.3	ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ОДООГИЙН БАЙДАЛ	83

5.4	МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ОДООГИЙН БАЙДАЛ _____	86
<b>6</b>	<b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИЖ БҮРЭН ҮНЭЛГЭЭ _____</b>	<b>89</b>
6.1	ЧОЙР ХОТЫН ДЭВСГЭР ГАЗАРТ ӨГӨХ БАЙГАЛЬ ОРЧНЫ НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ _____	90
6.2	ЧОЙР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭР ГАЗАРТ ӨГӨХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ 102	
6.3	ЧОЙР ХОТЫН ТӨВИЙН ДЭВСГЭР ГАЗАРТ ӨГӨХ ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ _____	108
6.4	ЧОЙР ХОТЫН ТӨВИЙН СУУРИНЫ ДЭВСГЭР ГАЗАРТ ӨГӨХ АРХИТЕКТУР, ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЛАНДШАФТЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ _____	112
6.5	ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИЖ БҮРЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ _____	113
<b>7</b>	<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ. ЧОЙР ХОТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА _____</b>	<b>115</b>
7.1	ГОВИЙН БҮСИЙН БОЛОН ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА _____	115
7.2	ӨМНӨХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ _____	117

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 3.1 Сумын төвийн ажиллах хүчний тоо.....	25
Хүснэгт 3.2 Сумын өрхийн тоо.....	26
Хүснэгт 3.3 Хүн амын тоо, багаар /2021 оны байдлаар/ .....	27
Хүснэгт 3.4 Малын тоо, толгой /мян.толгой/ .....	28
Хүснэгт 3.5 Малын тоо толгой /мянга/.....	28
Хүснэгт 4.1 Боловсролын байгууллагын ашиглалтын тодорхойлолт .....	35
Хүснэгт 4.2 Соёл урлагын барилгуудын ашиглалтын тодорхойлолт.....	42
Хүснэгт 4.3 Газрын нэгдмэл сангийн ангилалаар.....	45
Хүснэгт 4.4 Чойр хотын газар ашиглалтын одоогийн байдал, талбайн баланс /Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал/.....	47
Хүснэгт 4.5 Нийт эдэлбэр газрын хэмжээ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Хүснэгт 4.6 Говьсүмбэр аймгийн тээврийн хэрэгсэлийн тоо, төрлөөр .....	54
Хүснэгт 4.7 Чойр хотын тээврийн хэрэгсэлийн тоо, төрлөөр .....	55
Хүснэгт 5.1 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сумын газрын доорх усны ордууд.....	74
Хүснэгт 5.2 Говьсүмбэр аймаг, Сүмбэр суманд байрлах газрын доорх усны хяналтын цооногийн мэдээлэл.....	75
Хүснэгт 5.3 Эх үүсвэрийн судалгаа .....	75
Хүснэгт 5.4 Усан сангийн судалгаа.....	75
Хүснэгт 5.5 Халдваргүйжүүлэх байгууламж, тоног төхөөрөмжийн судалгаа .....	75
Хүснэгт 6.1 Байгаль орчны нэгдсэн үнэлгээний үзүүлэлт .....	90
Хүснэгт 6.2 Газрын гадаргын налууугийн үнэлгээ .....	92
Хүснэгт 6.3 Өндөржилт .....	92
Хүснэгт 6.4 Газрын гадаргын үнэлгээ.....	93
Хүснэгт 6.5 Барилгын уур амьсгал .....	93

Хүснэгт 6.6 Эрүүл ахуйн уур амьсгал.....	94
Хүснэгт 6.7 Уур амьсгалын үнэлгээ .....	94
Хүснэгт 6.8 Хөрсний үнэлгээ.....	95
Хүснэгт 6.9 Ургамлан бүрхэвчийн үнэлгээ .....	95
Хүснэгт 6.10 Ойн сан.....	96
Хүснэгт 6.11 Сэргээгдэх эрчим хүчний үнэлгээ .....	96
Хүснэгт 6.12 Ашигт малтмалын үнэлгээ.....	97
Хүснэгт 6.13 Байгаль экологийн үнэлгээний үзүүлэлт.....	97
Хүснэгт 6.14 Тоосны бохирдол .....	99
Хүснэгт 6.15 Дуу шуугианы бохирдол .....	99
Хүснэгт 6.16 Шингэн түлшний бохирдол .....	100
Хүснэгт 6.17 Хатуу түлшний бохирдол.....	100
Хүснэгт 6.18 Байгаль орчны бохирдол.....	101
Хүснэгт 6.19 Үерлэлт.....	101
Хүснэгт 6.20 Гуу жалга, гулсалт эвдрэл .....	102
Хүснэгт 6.21 Нийгэм эдийн засгийн үнэлгээний үзүүлэлт .....	102
Хүснэгт 6.22 Сургуулиудын хангамжийн түвшний үнэлгээ.....	104
Хүснэгт 6.23 Сургуулийн дотуур байрны хангамжийн түвшний үнэлгээ.....	105
Хүснэгт 6.24 Хүүхдийн цэцэрлэгүүдийн хангамжийн түвшний үнэлгээ .....	105
Хүснэгт 6.25 Өрхийн эмнэлгийн хангамжийн түвшний үнэлгээ.....	105
Хүснэгт 6.26 Ахуйн үйлчилгээний газруудын хангамжийн түвшний үнэлгээ .....	105
Хүснэгт 6.27 Өдөр тутмын зориулалттай үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн үнэлгээ	106
Хүснэгт 6.28 Тусгай зориулалттай үйлчилгээний байгууллагын хангамж .....	106
Хүснэгт 6.29 Хүн амын орон сууцны хангамжийн түвшний нэгдсэн үнэлгээ .....	106

Хүснэгт 6.30 Хүн амын орон сууцны хангамжийн түвшний үнэлгээ (нийтийн орон сууц).....	107
Хүснэгт 6.31 Хүн амын орон сууцны хангамжийн түвшний үнэлгээ /амины сууцны, гэр сууцны хороолол/.....	107
Хүснэгт 6.32 Суурьшлын бүсийн нягтралын үнэлгээ.....	107
Хүснэгт 6.33 Улс, бүс, орон нутгийн түвшинд хот, суурины гүйцэтгэх нэгдсэн үнэлгээ.....	107
Хүснэгт 6.34 Хот, суурины нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтийн нэгдсэн үнэлгээ.....	108
Хүснэгт 6.35 Дэд бүтцийн үнэлгээний үзүүлэлт.....	108
Хүснэгт 6.36 Зам, тээврийн үнэлгээ.....	109
Хүснэгт 6.37 Инженерийн хангамжийн үнэлгээ.....	109
Хүснэгт 6.38 Дулаан хангамжийн түвшний үнэлгээ.....	110
Хүснэгт 6.39 Ус хангамжийн түвшний үнэлгээ.....	110
Хүснэгт 6.40 Ариутгах татуургын сүлжээний үнэлгээ.....	110
Хүснэгт 6.41 Цахилгаан хангамжийн түвшний үнэлгээ.....	111
Хүснэгт 6.42 Холбоожуулалтын түвшний үнэлгээ.....	111
Хүснэгт 6.43 Инженерийн бэлтгэл арга хэмжээ.....	111
Хүснэгт 6.44 Архитектур, орон зайн төлөвлөлт, ландшафтын нэгдсэн үнэлгээ.....	112
Хүснэгт 6.45 Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний нэгдсэн дүн.....	114
Хүснэгт 7.1 Дулаан хангамжийн хэрэгжилтийн үе шат.....	125
Хүснэгт 7.2 Мэдээлэл холбооны хэрэгжилтийн үе шат.....	125
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	
Зураг 1.1 Байршлын схем.....	12
Зураг 1.2 Монгол орны цөлжилт 2020 он.....	14
Зураг 1.3 Говьсүмбэр аймгийн цөлжилт 2020 он.....	14
Зураг 1.4 Монгол улсын бэлчээрийн төлөв байдал ба нөхөн сэргэх чадавхийн ангилал, 2014 он байдлаар.....	15



Зураг 1.5 Монгол Улсын бэлчээрийн чадавхийн ангилал, 2014 он байдлаар.....	15
Зураг 2.1 Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл.	18
Зураг 2.2 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АЯЛАЛЫН МАРШРУТ .....	20
Зураг 3.1 Чойх хотын орчны тойм .....	21
Зураг 3.2 Чойр хотын байршлын схем .....	22
Зураг 3.3 Говьсүмбэр аймгийн төвийг тойрсон ухаа толгодууд .....	23
Зураг 4.1 Чойр хотын одоогийн байдал .....	31
Зураг 4.2 Чойр хотын одоогийн байдал .....	32
Зураг 4.3 Чойр хотын одоогийн байдал .....	33
Зураг 4.4 Чойр хотын ногоон байгууламжийн одоогийн байдал.....	34
Зураг 4.5 Чойр хотын ногоон байгууламжийн одоогийн байдал.....	34
Зураг 4.6 Чойр хотын ногоон байгууламжийн одоогийн байдал.....	35
Зураг 4.7 1-р Сургууль .....	36
Зураг 4.8 2-р Сургууль .....	36
Зураг 4.9 5-р Сургууль .....	37
Зураг 4.10 1-р Цэцэрлэгийн барилга .....	38
Зураг 4.11 2- Цэцэрлэгийн барилга .....	38
Зураг 4.12 Цэцэрлэгийн барилга .....	38
Зураг 4.13 Сансар цэцэрлэг.....	39
Зураг 4.14 Эмнэлгийн барилга /Нэгдсэн эмнэлэг/ .....	41
Зураг 4.15 Эмнэлгийн барилга /Хуучин/ .....	41
Зураг 4.16 Боржигин чуулга /Баригдаж байгаа/ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Зураг 4.17 Боржигин чуулга .....	43
Зураг 4.18 Хуучин соёлын төвийн барилга .....	43

Зураг 4.19 Сангийн далай хийд .....	44
Зураг 4.20 Аймгийн тамгын газрын барилга .....	44
Зураг 4.21 Сумын тамгын газрын барилга .....	45
Зураг 4.22 Газар ашиглалт судалгаа, талбайн баланс .....	46
Зураг 4.23 Эдэлбэр газрын хэмжээ .....	52
Зураг 4.24 Чойр хотын кадастрын зураг.....	53
Зураг 4.25 Гадна зам, тээвэр болон гудамж, замын одоогийн байдал.....	53
Зураг 4.26 Гадна зам, тээвэр болон гудамж, замын одоогийн байдал.....	54
Зураг 5.1 Чойр хотын орчны тойм .....	57
Зураг 5.2 Чойр хотын эх үүсвэрийн байрлал болон дулааны шугамын одоогийн байдал .....	58
Зураг 5.3 Чойр 20 Гкал/ц хүчин чадалтай Дулааны станц баригдаж буй байдал .....	70
Зураг 5.4 Дулаан хангамжийн угсралтын тойм байгуулалт.....	71
Зураг 5.5. Эх үүсвэрийн схем зураг .....	77
Зураг 5.6. Хуучин цэвэрлэх байгууламжийн байршил, одоогийн нөхцөл байдал .....	78
Зураг 5.7. Шинээр баригдаж байгаа цэвэрлэх байгууламжийн явц.....	79
Зураг 5.8. 35/6кВ Хонхор дэд станцын 6/0,4кВ фидерийн цахилгаан хангамжийн схем ... <b>Error!</b>	
<b>Bookmark not defined.</b>	
Зураг 5.9. 35/6кВ Хонхор дэд станц..... <b>Error! Bookmark not defined.</b>	
Зураг 5.10. Мэдээлэл холбооны сүлжээний станц .....	87
Зураг 7.1 Дэд бүтэц .....	115
Зураг 7.2 Аялал жуулчлал .....	116
Зураг 7.3 Тогтвортой хөдөө аж ахуй.....	117
Зураг 7.4 2002 оны Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт .....	118
<b>ГРАФИКИЙН ЖАГСААЛТ</b>	
График 3.1 Нас баралт, төрөлт, ердийн өсөлт .....	28

График 3.2 Малтай өрх .....	28
График 4.1 Газрын талбайн хэмжээгээр .....	52
График 6.1 Нэгдсэн үнэлгээний загварчлал .....	90
График 7.1 Хүн амын хэрэгжилт .....	119
График 7.2 Хүн амын хэрэгжилт /Сүмбэр/ .....	119
График 7.3 Нэгж хорооллын хэрэгжилт.....	119

## **ЧОЙР ХОТЫН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОЛОН ПРАКТИК ШААРДЛАГА**

### **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГА**

- Монгол Улсын үндсэн хуулийн 6-р зүйлийн 6.2-р заалтаар “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”;
- Газрын тухай хуулийн 56 дугаар зүйл 56.3. “Хот, тосгон, бусад суурины нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулахад дэд бүтцийн хангамж, хөгжлийн чиглэл, ариун цэвэр, эрүүл ахуй, экологи, галын аюулгүй байдлын шаардлага, газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөг үндэслэнэ;
- Хот байгуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.1 "хот байгуулалт" гэж түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, иж бүрэн тохижуулах цогцолбор үйл ажиллагааг” хэлнэ;

### **ПРАКТИК ШААРДЛАГА**

- Хөдөөгөөс хот руу чиглэсэн их нүүдэл буюу дотоод шилжилт хөдөлгөөн ихэссэн;
- Байгаль - экологийн даац хэтэрч агаар, хөрс, ус зэрэг хүрээлэн буй орчны бохирдол ихэссэн;
- Хот, суурин газруудын эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээний ачаалал нэмэгсэн;
- Сум, орон нутгийн инженерийн дэд бүтцийн хөгжил сул байгаагаас шалтгаалан хот, хөдөөгийн нийгэм, соёл, эрүүл мэнд, боловсролын заагийн ялгаа нэмэгдсэн;
- Хөдөөгийн сумдад ажлын байрны хомсдол үүсч, алслагдсан орон нутгийн хүн ам багассан;

### **ЗОРИЛГО**

- Монгол улсын урт, дунд, болон хугацааны бодлого, төлөвлөлтийн хөгжлийн баримт бичиг, тус сумын газарзүйн байршил түүх соёл, эдийн засаг, хүн ам болон голлох аж ахуйн онцлог, хөгжлийн хэтийн төлөв, хот байгуулалтын одоогийн байдлын судалгаа, үнэлгээнд тулгуурлан Говьсүмбэр аймгийн Чойр хотын ерөнхий төлөвлөгөөний тодотгол зураг төслийг боловсруулна.

## ҮНДЭСЛЭЛ

Говьсүмбэр аймгийн Чойр хотын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол зураг төсөл боловсруулах ажлыг Говьсүмбэр аймгийн Засаг даргын баталсан ГСАЕТ/05 дугаартай 2023 оны 04 дугаар сарын 25 ны өдөр зургийн даалгавар үндэслэн “СОНГОЛТ ДИЗАЙН” ХХК-нд хийж гүйцэтгэв.

Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулахад

- Хот байгуулалтын тухай хууль
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050 он”
- “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” /ХАНСЕТ/
- Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар БД 30-103-21
- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04
- Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар УББ 30-201-09
- Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт ба барилгажилт БД 30-101-05
- Говьсүмбэр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”
- “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль”
- “Усны тухай хууль”
- “Дулааны сүлжээ БНБД 41-02-13”
- “Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах БД 43-102-07”
- “Цахилгаан энергийн дамжуулалт хуваарилалт” баримт бичгийн “Хотын цахилгаан сүлжээ”

зэрэг голлох норм дүрмийг хэрэглэнэ.


# 1 НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАСАГ ЗАХИРГАА, ГАЗАРЗҮЙ, БАЙГАЛЬ ОРЧИН

## 1.1 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ

Улсын бага хурлын 1991 оны 6-р сарын 21-ны өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хотыг байгуулжээ. Харин Улсын Их Хурлын 1994 оны 5-р сарын 6-ны өдөр 32 дугаар тогтоолоор Чойр хотын хилийн цэсээр Говьсүмбэр аймаг 1994 оны 8 сард байгуулагдсан.

Говьсүмбэр аймаг нийт 5,540 км<sup>2</sup> нутагтай. Говьсүмбэр аймаг нь Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км-ийн зайд оршдог. Төв, Хэнтий, Дорноговь, Дундговь аймгийн сумтай хил залган байрладаг юм. Хойд талаараа Төв аймгийн Баянжаргалан, зүүн ба хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дархан, баруун болон өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэдэг.

Зураг 1-1 Байршлын схем



## 1.2 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УУР АМЬСГАЛ

### ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗАР ЗҮЙ, УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Говьсүмбэр аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Далайн түвшнээс дээш 1000-1200 метрийн өндөрт оршдог говь, тал хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм. Говьсүмбэр аймагт жилд унах тунадасны хэмжээ говийн бүсийнхээс илүү /дунджаар 200-250 мм/ бөгөөд температурын ялгаа зундаа +37, өвөл -37 градус байдаг.

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ЦӨЛЖИЛТ**

### **УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ**

Нутгийн дийлэнх газар нутаг нь хадат уул, тал хоолой зэрэг говь хээрийн нутаг хослосон тул мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой.


Жилийн дундаж хур тунадас 23,8 - 66,7 мм бөгөөд сүүлийн жилүүдэд хүчтэй салхи, шороон шуургын давтамж ихсэж, гамшигт үзэгдлийн тоо өссөн бөгөөд 2009 оноос цасан шуурганы давтагдал эрчимтэй ихсэж байгаа талаар ус, цаг уур, орчны судалгааны тайлан мэдээнд дурьдсан байна.

Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн судалгаанд дурьдсанаар дэлхийн уур амьсгалын өөрчлөлт Монгол оронд, түүний дотор Говьсүмбэр аймагт тодорхой хэмжээгээр илэрч байгаа нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд нөлөөлөх үйл явдал ажиглагдаж байна гэж үзэв. Энэхүү уур амьсгалын өөрчлөлтийн хандлага урт хугацаанд үргэлжилбэл тус нутгийн байгаль, экологийн тогтолцоо, биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлөх нь эргэлзээгүй болж байгаа юм.

### **ЦӨЛЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**


Монгол Улс нь газар зүйн байршлын хувьд эх газрын эрс тэс уур амьсгал зэргээс хамааран дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд эрчимтэй өртөж байгаа 10 орны нэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөгөөр дулааны улирлын хур тунадасны хэмжээ ихээхэн буурч хуурайших, гандуу болох, цөлжих үйл явц илүү ажиглагдаж байна. Сүүлийн 80 жилийн уур амьсгалын үндсэн үзүүлэлтийн ажиглалтаар улсын хэмжээнд дундаж байдлаар жилийн агаарын температур 2.25<sup>0</sup>-р дулаарч, хур тунадасны хэмжээ 8 хувиар буураад байна (MARCC, 2014).

Зураг 1-2 Монгол орны цөлжилт 2020 он



Эх сурвалж: “Байгаль орчин, аялал жуулчлалын яам”, 2021 он

Зураг 1-3 Говьсүмбэр аймгийн цөлжилт 2020 он






Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2021 он

2020 оны байдлаар Монгол орны цөлжилтийн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай доройтсон. Үүнээс нэн хүчтэй доройтолд өртсөн 4.7 хувь, хүчтэй доройтолд өртсөн 18.6 хувийг эзлэх ба Засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь, Дундговь, Өмнөговь, **Говь-сүмбэр**, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн нийт газар нутгийн 50 – 70 хувь цөлжилт болон газрын доройтолд өртсөн байна.

### Монгол Улсын бэлчээрийн өнөөгийн байдал

Ус цаг уурын улсын сүлжээн дээрх бэлчээрийн мониторингийн 1,450 цэгийн тоон мэдээллийг бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн харгалзах загварт дүйлгэн үнэлгээжүүлсэн байна. Цэгүүдээ бэлчээрийн сэргэх чадавхийн ангилалаар ангилж үзвэл 48 хувийнх нь нөхөн сэргэхэд 3-аас цөөнгүй менежментийн жил шаардагдахаар байна. 52 хувь нь ангилал I-д, 25 хувь нь ангилал II-т, 15 хувь нь ангилал III-д, 7 орчим хувь нь ангилал IV-д тус тус хамрагдаж байна.


Зураг 1-4 Монгол улсын бэлчээрийн төлөв байдал ба нөхөн сэргэх чадавхийн ангилал, 2014 он байдлаар



Эх сурвалж: Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2015 он ([https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/Mongolia-Rangeland-Health-Report\\_MN.pdf](https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/Mongolia-Rangeland-Health-Report_MN.pdf))

Сэргэх чадавхиар нь ангилсан дүнгээ байгалийн бүсээр нь харьцуулж үзэхэд цөлөрхөг хээр, цөлийн бүс дэх цэгүүд байршиж байгаа бэлчээр харьцангуй байгалийн унаган 18 төлөвөөрөө байгаа, эсвэл багахан хэмжээгээр өөрчлөгдсөн байна (Ангилал I). Ойт хээр, хээр, цөлжүү хээрийн бүсийн цэгүүд байгаа бэлчээрийн дийлэнх нь (Ангилал II-IV) сэргээн сайжруулахад дор хаяж 3, түүнээс олон жил шаардагдахаар төлөв байдалд байна.

Зураг 1-5 Монгол Улсын бэлчээрийн чадавхийн ангилал, 2014 он байдлаар



Архангай, Булган, Төв, Сэлэнгэ, Дундговь аймгийн **бэлчээр доройтолд үлэмж өртөгдөж хамгийн их талхлагдсан, I буюу II гэсэн ангилалд багтах бэлчээр эзлэх хувиар бусдаас бага байна.**

Монгол Улсын нутаг дэсвгэрийн онцлох шинж чанарт үндэслэн хөдөө аж ахуйн газар тариалан, мал аж ахуйн салбар үйлдвэрлэлийн хөгжлийн нэг хэсэг нь байдаг нь нийгэм, эдийн засагт нөлөөлөхүйц өөрчлөлт, хөгжүүлэлт бий болгож чадахгүй байгаа нь сул тал болж байна.

## **2 ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ**

### **2.1 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ**

Аймгийн эдийн засгийн салбарын хувьд бусад орон нутгаас ялгаатай тал нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлал хөгжсөн. Аймгийн 2022 оны ДНБ-ийг салбараар харуулбал: худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийн салбар 55 хувийг, хөдөө аж ахуйн салбар 25 хувийг, үйлдвэрлэлийн салбар 20 хувийг эзэлж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Говьсүмбэр аймаг 18042 хүнтэй болж, үүнээс эрэгтэй 8979, эмэгтэй 9063 байна. Өмнөх онтой харьцуулбал хүн ам 110 буюу 0.6 хувиар, үүнээс эмэгтэй 43 буюу 0.5 эрэгтэй 68 буюу 0.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарлаа. Нийт хүн амын 49.9 хувийг эрэгтэйчүүд, 50.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт хүн амын 6637 буюу 36.8 хувийг 0-14 насны хүүхэд, 10104 буюу 56.0 хувийг 15-59 насны хүмүүс, 1301 буюу 7.2 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна.

### **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**


1. Уул уурхай
2. Тээвэр логистик
3. Хөдөө аж ахуй
4. Аялал жуулчлал

### **2.2 УУЛ УУРХАЙ**

Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, инновацыг нутагшуулах замаар нэмүү өртөг шингэсэн уул уурхай.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхай Чойр хотоос урагш орших 2,7 тэрбум тонн хүрэн нүүрсний нөөцтэй орд уурхай юм. Энэ уурхай нь аймгийн төсвийн ихэнх хувийг бүрдүүлдэг, Монголдоо дээгүүрт тооцогдох том уурхай болно.

Зураг 2-1 Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл



### Шивээ-Овоогийн уурхай

- Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын нөөц 2,7 тэрбум тонн
- Уурхайн ашиглалт явуулж буй “Шинэ-Ус” талбайн нөөц 646 сая тонн
- Уурхай нь Монгол улсын эрчим хүчний нүүрний хэрэглээний 30 орчим хувийг хангадаг
- Жилд хоёр сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай
- Сүүлийн 5 жилд, жилдээ 2 сая-с дээш тонн нүүрсний борлуулалт хийсэн
- Улсын төсөвт Говьсүмбэр аймгаас оруулж буй нийт төсвийн орлогын 80 орчим хувийг бүрдүүлдэг.
- 2022 онд 67 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон үзүүлэлттэй ажиллаж байна.

### 2.3 ТЭЭВЭР ЛОЖИСТИК

Уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, газар нутгийн байршил, зам тээвэр, харилцаа, холбоо, дэд бүтцийн давуу байдалд түшиглэсэн тээвэр, логистик. Говьсүмбэр аймаг нь Монгол улсын ачаа тээврийн гол зам болох Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн авто зам, төмөр зам дагуу байрладаг нь тээвэр логистик хөгжсөн байна. Говь-сүмбэр аймаг нь хил залгаа Дундговь аймгийн уул уурхай гол ордуудтай ойрхон байрлаж байна.

Зам, тээврийн дэд бүтцийн сүлжээний зураг



## 2.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ

1931онд Оцол Сансар уулын хошууны одоогийн Төв аймгийн тэр үеийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд сум дундын мал эмнэлгийн алба анх байгуулагджээ.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтцэд Мал үржлийн, Мал эмнэлгийн, Газар тариалан, Санхүүгийн алба мөн сумдын 6 мал эмнэлэг, үржлийн нэгжтэй хамтран үйл ажиллагаагаа явуулж байгаал 2009 оноос Хүнс, хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газар болж дотроо Мал үржлийн , Мал эмнэлгийн, Бодлого зохицуулалтын гэсэн албадтай болсон.

2013 оноос Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар болж Захиргаа удирдлагын хэлтэс, Үйлдвэр газар тариалангийн хэлтэс, Мал аж ахуйн хэлтэс, Мал эмнэлгийн хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байв. Харин 2014 оноос Хүнс, хөдөө аж ахуйн газар болон өөрчлөгдөж Захиргаа удирдлагын хэлтэс, Хүнс, газар тариалангийн хэлтэс, Мал аж ахуйн хэлтэс, Мал эмнэлгийн гэсэн дөрвөн хэлтэстэй дэргэдээ Цөм сүрэг үржлийн төвтэйгөөр ажиллаж байна.

Малын төрөл	Улсын дүн	Говьсүмбэр	Сүмбэр	Баянтал	Шивээговь
Бүгд	71,120.43	464.29	339.83	72.04	52.43
Адуу	4,821.01	27.73	19.72	5.42	2.6
Үхэр	5,512.80	19.72	13.56	3.17	2.99
Тэмээ	470.46	1	0.69	0.11	0.21
Хонь	32,747.16	236.02	172.26	39.19	24.57
Ямаа	27,569	179.82	133.6	24.16	22.06


## 2.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Аймгийн ард түмний шүтээн уул. Зүүн жанжин Чойрын хийд нь энэ ууланд байв. Бурхан шашны олон дурсгалт зүйлүүд байдаг.

Зүүн чойрын хийд Жанжин бэйлийн хошууны Зүүн чойр хийдийг Богд уулын “Марзана хоолой Мандлын таван хад” хэмээх энэхүү газарт Тэнгэр тэтгэгчийн дөчингуравдугаар (1778) он, XIII жарны шороон нохой жилд Жанжин төрийн ёст мэргэн жонон далай дархан хун тайж, бэйл Дагдандорж ноён байгуулав.

Энэ хийдийн түвэд нэр нь “Балдандашгомалин”. тус хошуун дахь бүх шашныг төвлөн захирдаг. Энэ хийд нь Гүнчин игчаны дэгээр гүн ухааны сургалт явуулдаг, буддийн гүн ухааныг судалдаг, анагаах ухаан, цагийн хүрдний онол, тарнийн гүн ухааныг судлах дацангууд бүхий 1500 ламын данстай, хошууныхаа хамгийн том хийд байв. 1853 онд зүүн чойр дээр Дүйнхор дацан байгуулагдсан. Зүүн Чойрын хийд дээр боржигин Сэцэн вангийн хошууны ноён Цэрэнсандивын урилгаар Гүмбүм хийдийн Сэрдог номун хан Чүлтэмжамц саатан морилж олон зохиол туурвисан гэдэг.

Зураг 2-2 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АЯЛАЛЫН МАРШРУТ




### 3 ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЧОЙР ХОТЫН ОДООГИЙН БАЙДАЛ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Чойр нь Говьсүмбэр аймгийн төв юм. Чойр нь Сүмбэр сумын төвд оршдог. Далайн түвшнээс дээш 1269 метрт оршино.

Чойр хот хуучин Сэцэн хан аймгийн Боржигин Цэцэн вангийн хошууны төв бөгөөд Боржигины уг гарал нь Монгол төрийг нэгтгэн захирч байсан Батмөнх даян хааны отгон хүү Гэрсэнз хун тайжийн удмын Далай хун тайжийн том хүү Цэвдан 1691 оны Цагаагчин хонин жил Сэцэн хан аймгийн Боржигон хошууг байгуулж \*Засаг бэйл\* хэргэм эдлэх болсон гэж түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэн үлджээ.

*Зураг 3-1 Чойр хотын орчны тойм*



Зураг 3-2 Чойр хотын байршлын схем



### 3.1 ИНЖЕНЕР ГЕОЛОГИ ДҮГНЭЛТ

#### ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

Энэхүү инженер-геологийн дүгнэлт нь Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний шинээр төлөвлөлт хийж буй нутаг дэвсгэрийн инженер-геологи, гидрогеологи, физик- геологийн нөхцлийг үнэлж хөгжлийн ерөхий чиглэл тогтоох, орон сууцны болон үйлдвэрийн цогцолборууд болон шугаман байгууламжийн чиглэл тогтоох, төлөвлөх үндэслэл болно.

Чойр хотын нутаг дэвсгэрт 1992 онд инженер-геологийн 1:5000 масштабтай зураглал судалгааны ажил, 1988 онд хотын нутаг дэвсгэрийн зарим хэсэг усанд автсантай холбогдуулан явуулсан гидрогеологийн судалгааны ажил нь энэхүү ерөнхий төлөвлөгөөний шинэчлэлд зориулсан инженер-геологийн нөцлийн дүгнэлт бичих, тодруулалт хийх үндсэн тулгуур материал болов.

Дээрх судалгааны ажлын хийгдсэнээс хойш Чойр хотын төвд онцгойлон авч үзэх томоохон барилга байгууламж шинээр барьж байгуулсан зүйлгүй учир одоогийн байдлаар инженер-геологийн нөхцлөөс хамаарч барилга байгууламжид нөлөөлсөн гэх нөхцөл хүчин зүйл ажиглагдахгүй байна.

Чойр хотын нутаг дэвсгэрт маш олон нэр төрлийн, онцгой шинж чанар төлөв байдалтай хөрс тодорхой зүй тогтолгүй тархдаг инженер-геологийн нийлмэл тогтоцтой.



**Уул зүй:** Хотын нутаг дэвсгэрийн зүүн хэсгийн гүвээ толгод тохилдох ба бусад хэсэг нь тэгш талархаг тогтоцтой. Их сансар 1682.5, Улаан толгой 1523.7, Хөшөөт өндөр 1451.6, Зараа толгой 1444.3, Чулуут толгой 1381.0 зэрэг нам өндөртэй уулс гүвээ, толгод нутаг дэвсгэрийн зүүн хэсгээр холоос харагдана.

*Зураг 3-3 Говьсүмбэр аймгийн төвийг тойрсон ухаа толгодууд*



Гадаргуугийн усан сүлжээ: Хотын болон орчны хэмжээнд гадаргуугийн усан сүлжээгүй, байнгийн урсгалтай гол, горхи, булаг шанд байхгүй. Зөвхөн ухаа гүвээт талын хонхор хотгоруудад ширгэдэг жижиг нуур, тогтоол ус тохиолдоно. Сумын төвийн зүүн урд талаар Ар цагааны гол, Өгөөмөрийн гол, Царай гашууны булаг зэрэг хур бороотой үед урсацтай болдог хуурай сайрууд тохиолддоно. Лүнгийн ураан нуур, Лүнгийн шанд жижиг нуур, цөөрмүүд сумын баруун баруун хойд хэсгээр оршдог. Эдгээр нуур нь бага талбайтай, давс хужирлаг устай. Төмөр замын соёлын ордны барилгын зүүн хойд талд 50х30м орчим, баруун талд 80х20м орчим талбайтай хонхруудад хур тунадас элбэг жилд жижиг тогтоол ус тойром үүсдэг ба гантай жилд ширгэж хатдаг байна. 1980-90- ээд онд хуучнаар Зөвлөлтийн цэргийн анги нэгтгэлүүдийн хорооллын хэрэглээний усыг орчны хонхор газруудад хаянаас хиймэл нуурууд үүсэж байсан. 1980-аад оны үед гүний худгаас даралттай ус оргилон их хэмжээнд гадаргуугийн усанд нөлөөлөх байгалийн хүчин зүйл нь агаарын хур тунадаснаас гадна хүний үйл ажиллагааны нилээд голлох нөлөөлөлтэй байна.



Зураг № 8 Говьсүмбэр аймгийн төв  
Хуучин оросын цэргийн анги байсан бохирын  
хаягдлын талбай

Зураг № 9  
Сүмбэр сумын төвийн хуучин бохирын  
хаягдлын талбай



**Уур амьсгалын онцлог:** Монгол орны нутаг дэвсгэрт барилга хот төлөвлөхөд зориулсан уур амьсаглын бүсчлэлээр Чойр хот харьцангуй хүйтэн өвөлтэй, шороон шуурга, салхи ихтэй, хуурай- халуун зунтай, хүйтэн сэрүүвтэр намартай, цасны ачаалал харьцангуй их, уур амьсгалтай II бүсэд хамаарна. Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23-01-09-ын заалтаар Говь-Сүмбэр аймаг Чойр, Сүмбэр цаг уурын станцын үзүүлэлтээр өглөө.

- |   |                        |
|---|------------------------|
| • Агаарын жилийн температурын дундаж утга               | 0.3°C                  |
| • Агаарын температурын хамгийн их утга                  | 39.6°C                 |
| • Хамгийн дулаан үеийн агаарын температур               | 32.1°C                 |
| • Агаарын температурын хамгийн бага утга                | -39.3°C                |
| • Хамгийн хүйтэн үеийн агаарын температур               | -30.2°C                |
| • Гаднах агаарын тооцооны температур утга:              |                        |
| ▪ Хамгийн хүйтэн 5 өдөр                                 | -30.7°C                |
| ▪ Хамгийн хүйтэн 3 өдөр                                 | -31.9°C                |
| ▪ Хамгийн хүйтэн 1 өдөр                                 | -33.2°C                |
| • Хур тунадасны жилийн дундаж хэмжээ                    | 193.8мм                |
| • Хэвтээ гадаргын дээрхи цасны ачааллын нормчилсон утга | 50 кг/м <sup>2</sup>   |
| • Салхины даралтын нормчилсон утга                      | 35.0 кг/м <sup>2</sup> |
| • Салхины жилийн дундаж хурд                            | 3.2 м/с                |
| • Галлагааны хугацааны тооцооны үзүүлэлтүүд:            |                        |

Эхлэх өдөр	Дуусах өдөр	Үргэлжлэх хоног	Халаалтын улирлын тооцооны дундаж t, °C	Халаалтын улирлын эрчим, град °C (-t)
24.IX	4.V	222	-10.7	-2372.4

### 3.2 ЧОЙР ХОТЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

#### 3.2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2022 оны байдлаар Говьсүмбэр аймгийн хэмжээнд 5281 хүн хөдөлмөр эрхэлж байна. Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуй, уул уурхайн салбар тэргүүлэх салбар байна. Нийт ажиллагсадын 28.25 хувь хөдөө аж ахуйн салбарт тэр дундаа мал аж ахуйн, 22.13 хувь уул уурхайн олборлолт буюу Шивээгийн уурхайд ажиллаж байна.

Хүснэгт 3-1 Сумын төвийн ажиллах хүчний тоо


Салбар	Улсын дүн		Говьсүмбэр		Тэргүүлэх салбар
	2022	Эзлэх хувь	2022	Эзлэх хувь	
<b>Бүгд</b>	1,180,474	100	5,381	100	
<b>Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур</b>	293,974	24.9	1,520	28.25	3.34
<b>Уул уурхай, олборлолт</b>	60,342	5.11	1,191	22.13	17.02
<b>Боловсруулах үйлдвэрлэл</b>	112,665	9.54	100	1.86	-7.69
<b>Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж</b>	22,040	1.87	76	1.41	-0.45
<b>Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа</b>	6,835	0.58	0	0.00	-0.58
<b>Барилга</b>	77,527	6.57	221	4.11	-2.46
<b>Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ</b>	146,236	12.3	263	4.89	-7.50
<b>Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа</b>	68,175	5.78	387	7.19	1.42
<b>Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ</b>	32,019	2.71	21	0.39	-2.32
<b>Мэдээлэл, холбоо</b>	19,155	1.62	0	0.00	-1.62
<b>Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа</b>	22,570	1.91	68	1.26	-0.65
<b>Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа</b>	2,472	0.21	0	0.00	-0.21
<b>Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа</b>	15,132	1.28	0	0.00	-1.28
<b>Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа</b>	13,930	1.18	0	0.00	-1.18
<b>Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал</b>	82,129	6.96	420	7.81	0.85
<b>Боловсрол</b>	104,397	8.84	529	9.83	0.99
<b>Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа</b>	49,659	4.21	379	7.04	2.84
<b>Урлаг, үзвэр, тоглоом, наадам</b>	14,114	1.20	57	1.06	-0.14
<b>Үйлчилгээний бусад үйл ажиллагаа</b>	34,180	2.90	80	1.49	-1.41
<b>Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа</b>	951	0.08	69	1.28	1.20
<b>Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа</b>	1,974	0.17	0	0.00	-0.17

*Handwritten signature and initials*

### 3.2.2 ХҮН АМ

2022 оны байдлаар Сүмбэр сум 6 баг нийлээд 13,176 хүн амтай ба Чойр хотод 10830 хүн ам бүртгэлтэй байгаа боловч бусад 6 багийн малчин өрхийн хүн ам, түр хүн амтай нийлээд 1500 гаруй хүн оршин сууж байна.

Баг, хороо	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
<b>Говьсүмбэр</b>	15,891	16,308	16,934	17,399	17,489	17,445	18,008	18,153	18,042
<b>Сүмбэр</b>	11,609	11,881	12,352	12,710	12,773	12,704	13,082	13,152	13,176
<b>1-р баг</b>	2,743	2,837	2,758	2,798	2,736	2,918	2,989	2,861	2,772
<b>2-р баг</b>	3,083	3,116	3,227	3,315	3,352	3,300	3,376	3,351	3,401
<b>3-р баг</b>	3,876	3,853	4,156	4,321	4,359	4,209	4,401	4,619	4,657
<b>4-р баг</b>	680	747	768	774	821	817	851	827	824
<b>5-р баг</b>	658	698	731	744	753	744	731	745	755
<b>6-р баг</b>	569	630	712	758	752	716	734	749	767
<b>Баянтал</b>	1,084	1,168	1,204	1,240	1,201	1,129	1,105	1,179	1,157
<b>1-р баг</b>	746	767	782	790	756	722	712	783	767
<b>2-р баг</b>	338	401	422	450	445	407	393	396	390
<b>Шивээговь</b>	3,198	3,259	3,378	3,449	3,515	3,612	3,821	3,822	3,709
<b>1-р баг</b>	1,993	2,088	2,244	2,299	2,365	2,546	2,720	2,727	2,617
<b>2-р баг</b>	1,205	1,171	1,134	1,150	1,150	1,066	1,101	1,095	1,092




Хүснэгт 3-2 Сумын өрхийн тоо

Баг, хороо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
<b>Говьсүмбэр</b>	4,680	4,749	5,017	5,189	5,364	5,388	4,979	5,061	5,261	5,265
<b>Сүмбэр</b>	3,390	3,423	3,632	3,754	3,878	3,899	3,634	3,682	3,821	3,848
<b>1-р баг</b>	743	784	796	799	805	792	759	786	830	823
<b>2-р баг</b>	982	931	1,009	1,022	1,059	1,059	1,003	1,012	1,010	1,004
<b>3-р баг</b>	1,090	1,108	1,167	1,227	1,285	1,316	1,186	1,175	1,243	1,273
<b>4-р баг</b>	204	221	243	247	250	260	243	258	259	266

5-р баг	208	207	220	233	233	232	225	219	240	244
6-р баг	163	172	197	226	246	240	218	232	239	238
Баянтал	318	331	360	387	418	410	338	340	360	359
1-р баг	217	223	234	242	256	242	197	198	219	218
2-р баг	101	108	126	145	162	168	141	142	141	141
Шивээговь	972	995	1,025	1,048	1,068	1,079	1,007	1,039	1,080	1,058
1-р баг	600	603	640	679	693	702	687	722	741	725
2-р баг	372	392	385	369	375	377	320	317	339	333

Эх сурвалж: 1212.тн, 2023 он



Хүснэгт 3-3 Хүн амын тоо, багаар /2021 оны байдлаар/


Нас баралт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бүгд	16,521	17,620	17,763	17,357	17,864	18,403	17,040	20,856	19,301
Говьсүмбэр	84	93	115	101	90	86	91	127	113

Төрөлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Улсын дүн	82,839	82,130	79,920	75,321	78,444	79,580	77,716	73,253	66,910
Говьсүмбэр	497	449	461	408	498	445	426	456	389
Сүмбэр	355	335	342	300	364	340	319	339	296
Баянтал	35	42	29	23	41	29	26	31	28
Шивээговь	108	72	90	85	93	76	81	86	65

Эх сурвалж: 1212.тн, 2023 он

Говьсүмбэр аймгийн Чойр хотын хүн ам сүүлийн жилүүдэд цэвэр өсөлт дунджаар 2.02 хувийн өсөлттэй байна. Гэвч аймгийн нийт хүн амын өсөлт 1.6 хувьтай байгаа нь аймгийн хэмжээнд гадагшаа чиглэлтэй шилжилт хөдөлгөөнтэй байна.

График 3-1 Нас баралт, төрөлт, ердийн өсөлт



### 3.3 ХӨДӨӨ АЖ АХУЙ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын эдийн засгийн голлох нэг салбар нь мал аж ахуйтай холбоотой бөгөөд сүүлийн 10-аад жилийн байдлаар сумын мал сүргийн тоо тогтмол өсөлттэй байна. Харин 2021 он тооллого мэдээллээр буурсан байна. Аймгийн нийт хөдөлмөр эрхлэгчдын 22 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад байгаагаас 1166 малтай өрх байна.

Хүснэгт 3-4 Малын тоо, толгой /мян.толгой/

Малын төрөл	Улсын дүн	Говьсүмбэр	Сүмбэр	Баянтал	Шивээговь
Бүгд	71,120.43	464.29	339.83	72.04	52.43
Адуу	4,821.01	27.73	19.72	5.42	2.6
Үхэр	5,512.80	19.72	13.56	3.17	2.99
Тэмээ	470.46	1	0.69	0.11	0.21
Хонь	32,747.16	236.02	172.26	39.19	24.57
Ямаа	27,569	179.82	133.6	24.16	22.06

Эх сурвалж: 1212.тп, 2021 он

График 3-2 Малтай өрх


Аймаг	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Улсын дүн	209,933	213,363	216,734	223,761	228,950	230,854	233,317	242,024	246,302	248,296
Говьсүмбэр	872	950	994	1,055	1,041	1,011	1,022	1,118	1,156	1,166

Хүснэгт 3-5 Малын тоо толгой /мянга/

Малын төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бүгд	272.76	339.44	379.48	397.91	438.41	427.46	452	451	432.2	464.29
Адуу	12.12	14.97	18.15	20.25	22.27	20.59	22.74	22.69	24.27	27.73
Үхэр	7.7	10.36	12.39	13.65	14.9	14	14.54	16.35	17.81	19.72
Тэмээ	0.82	0.87	0.87	0.82	0.93	1.06	0.99	1.09	1.07	1

<b>Хонь</b>	120.9 5	152.2 6	169.0 9	185.8 8	205.2 3	208.0 8	219.5 3	218.4 3	219.4 2	236.0 2
<b>Ямаа</b>	131.1 7	160.9 8	178.9 8	177.3 1	195.0 8	183.7 2	194.2 1	192.4 4	169.6 3	179.8 2
<b>Сүмбэр</b>										
<b>Бүгд</b>	198.7 3	245.3	278.3 9	295.3 6	324.0 3	309.7 1	325.9 3	322.0 7	317.8 6	339.8 3
<b>Адуу</b>	8.33	10.19	12.99	14.53	15.77	14.24	15.58	15.75	17.08	19.72
<b>Үхэр</b>	5.6	7.36	8.88	9.95	11.1	9.53	9.9	10.82	12.19	13.56
<b>Тэмээ</b>	0.58	0.61	0.64	0.57	0.65	0.72	0.68	0.78	0.75	0.69
<b>Хонь</b>	86.61	109.1 4	123.6	136.6 6	151.0 2	150.0 2	157.0 9	154.9 2	160.7	172.2 6
<b>Ямаа</b>	97.61	118	132.2 8	133.6 6	145.4 9	135.2 1	142.6 8	139.7 9	127.1 4	133.6
<b>Баянтал</b>										
<b>Бүгд</b>	42.17	53.24	57.37	59.12	66.34	67.33	70.68	69.71	65.33	72.04
<b>Адуу</b>	2.68	3.4	3.64	4.16	4.64	4.36	4.98	4.7	4.92	5.42
<b>Үхэр</b>	1.03	1.59	1.93	2.09	2.01	2.36	2.44	2.78	2.93	3.17
<b>Тэмээ</b>	0.16	0.17	0.14	0.14	0.15	0.16	0.13	0.13	0.12	0.11
<b>Хонь</b>	19.88	25.17	26.2	28.37	32.03	34.55	37	37.03	36.02	39.19
<b>Ямаа</b>	18.42	22.92	25.47	24.35	27.52	25.88	26.14	25.06	21.34	24.16
<b>Шивээговь</b>										
<b>Бүгд</b>	31.87	40.89	43.71	43.43	48.04	50.42	55.39	59.23	49.01	52.43
<b>Адуу</b>	1.11	1.38	1.52	1.56	1.86	1.99	2.18	2.23	2.27	2.6
<b>Үхэр</b>	1.07	1.4	1.58	1.61	1.8	2.11	2.21	2.74	2.69	2.99
<b>Тэмээ</b>	0.08	0.09	0.09	0.11	0.13	0.18	0.18	0.18	0.2	0.21
<b>Хонь</b>	14.47	17.96	19.29	20.85	22.18	23.51	25.44	26.48	22.7	24.57
<b>Ямаа</b>	15.14	20.06	21.23	19.3	22.07	22.63	25.39	27.59	21.15	22.06

Эх сурвалж: 1212.тн, 2023 он



## **4 ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАРИЛГАЖИЛТ, ГАЗАР АШИГЛАЛТ, ЗАМ ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭНИЙ ОДООГИЙН БАЙДАЛ**

### **4.1 ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГАЖИЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ**

Говьсүмбэр аймаг нь хуучнаар Сэцэнхан аймгийн Боржигин сэцэн вангийн төв хэсэг, үндсэн нутаг юм. Улсын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тогтоолоор Чойр хотын 5.5 мян.км<sup>2</sup> талбай бүхий хилийн цэсийн нутаг дэвсгэрт Говьсүмбэр аймгийг 1994 оны VIII сард байгуулсан байна. Газарзүйн байршлын хувьд хойд талаараа Төв аймгийн Баянцагаан, Баян, Баянжаргалан сумдтай зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Дархан сумдтай, баруун болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдтай тус тус хил залган оршдог, зам харилцаа, инженерийн дэд бүтэц хөгжсөн учир үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, аялал жуулчлалын салбар болон олон барилга байгууламжтай хот юм.

Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт Улаанбаатар хотоос 250 км-ийн зайд оршдог. Хотын нутаг дэвсгэр дээгүүр олон улсын транзит төмөр зам болон агаарын коридор дайран өнгөрдөг. Ачаа тээврийн, иргэний зорчигч тээвэрлэх бүх төрлийн даацын онгоц хөөрч буух 3 км урттай, 72м-ийн өргөнтэй 2 зурвас бүхий онгоцны буудалтай, Налайх-Чойрын чиглэлийн 200 км хатуу хучилттай замтай, цахилгаан эрчим хүчний дамжуулах станцтай.

Чойр нь Тэрэгтийн хөндий хэмээх газар бэсрэг өндөртэй цав, жижиг толгодын хооронд тэгшивтэр дэвсэг хэсэгт байрладаг. Төвийн хэсэгт 2-3 газарт тогтоол ус-тойром байдаг ба зарим нь ширгэдэггүй, бороотой үед ус нь нилээд ихэсдэг байна. Гэр хорооллын баруун урд жижиг тойромд байнгын ус тогтдог. Салхины чиг нь ихэвчлэн баруун хойноос байх ба салхины хоногийн хэлбэлзэл ихтэй.

Говьсүмбэр аймгийн Чойр хотын Сүмбэр сумын 2500 га талбайг өнөөгийн байдлаар гэр хороолол, нам давхар орон сууц, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, орон нутгийн захиргаа, сургууль цэцэрлэгийн эдэлдбэр газар, уул уурхайн бүтээгдэхүүний шилжүүлэх ачих, төмөр замын зурвас газар өртөө, авто замын газар зэргээр ашиглаж байна.



Зураг 4-1 Чойр хотын одоогийн байдал



Эх сурвалж: “Сонголт дизайн” ХХК-ны талбайн судалгаа /2023.08.29-30/

2004, 2014 онуудад Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байсан.

**Суурьшил:** Говьсүмбэр аймаг нь 3100 өрхтэй, үүнээс Чойр хотод 1481 өрх орон сууцанд, 1619 өрх хашаа байшинд амьдардаг байна.

2004 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөгдсөн Хонхор хотхоны 5-н давхар угсармал орон сууцны хороолол нь газар ашиглалт сайтай, нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй төлөвлөгдсөн байна.

Төмөр замын хэсэг нь хувьчдагдсан дан болон 2 давхар орон сууц, худалдаа үйлчилгээ, соёлын ордон, эмнэлэг, цэцэрлэг, сургууль байдаг бөгөөд барилгажилтын нягтрал муутай байна.

Гэр хороолол нь хотын баруун талд мөн зүүн, зүүн хойд хэсэгт алслагдсан байдалтай, нийгмийн үйлчилгээ хүрэх боломжгүй, хашааны газар олголт нь замбараагүй, дэд бүтэц татах, гудамжлан зам тавих боломжгүйгээр газар олголт хийгдсэн байна.

Чойр хотын иргэд орон сууцтай, газар өмчлөн авах эрхийн дагуу газар авсан ч ашиглахгүй, олгогдсон газруудад нийгмийн үйлчилгээ, хороо, сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, халуун ус, галын болон түргэн тусламжийн үйлчилгээ хүрэх боломжгүйгээр төлөвлөлтгүй газар олголт хийгдсэн байна.

Зураг 4-2 Чойр хотын одоогийн байдал



Эх сурвалж: “Сонголт дизайн” ХХК-ны талбайн судалгаа /2023.08.29-30/

**Худалдаа үйлчилгээ:** Чойр хотын Төмөр замын гудамж дагасан авто замын дагуу мөн Хонхор хотхонд авто зам дагуу банк дэлгүүрүүд гэх мэт хувийн хэвшлийн байгууллагууд байрладаг. Зарим худалдаа үйлчилгээ нь орон сууцны 1 давхарт байрлан үйлчилгээ үзүүлдэг байна.

**Үйлдвэрлэл:** Төмөр зам, төмөр замын өртөөний хойд талбайд нефть бааз, агуулахын зориулалттай 3 компани, баруун талд улсын өвсний нөөцийн газар, УБТЗ-ын ачиж буулгах анги, УБТЗ-ын эрчим хүчний хэсэг, замын 3 дугаар анги, нефть бааз, агуулах, жоншны баяжуулах үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр, үйлчилгээ эрхлэдэг компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна.

**Нийтийн эзэмшил:** Хот хоорондын замын урд талд Стадион, Орос цэргийн хөшөө байна.

**Төрийн байгууллага:** Засаг захиргааны ордон, сургуулийн орчим, цэцэрлэгийн орчим, эмнэлгийн орчим, цагдаагийн байгууллагын газрууд, онцгой байдал, шүүхийн, хорих анги зэрэг нь төрийн мэдлийн газарт харъяалагддаг байгууллагууд хотын төв болон баруун өмнө талд байрладаг.

**Тусгай хэрэгцээний газар:** Төмөр замын өртөө, Гал команд, Хорих анги, Цахилгаан хангамжийн дэд өртөө, Усан сан, Өвсний фондын, Хог хаягдлын цэг, Оршуулгын газар хамаарна.

**Олон нийтийн амралт зугаалгын газар** Одоогийн байдлаар Чойр хотод стандартын шаардлага хангах амралт зугаалга байхгүй. Төмөр замын соёлын төвийн баруун талд цэцэрлэгт хүрээлэн, Хонхор хотхоны урд талд 2000 хүний суудал бүхий стадион байрлана.

**Нөөц талбай:** Чойр хотын хот хоорондын автозамын баруун талд спорт, амралт зугаалгын бүсийн нөөц талбай, одоо байгаа гэр хорооллын хойд талд суурьшлын бүс төлөвлөх нөөц талбай, хот хоорондын замын зүүн талд болон Хонхор хотхоны 5 давхар орон сууцны барилгуудын баруун хойд талд 1000 айлын орон сууцны хорооллын нөөц газраар төлөвлөгсөн ч цахилгаан шугам /110 кВТ/ хийгдсэн , Хонхор хотхоны 5 давхар орон сууцнуудын зүүн урд талд орос баатрын хөшөөний зүүн, зүүн урд хэсэгт үйлдвэрийн нөөц талбай тус тус байна.

*Зураг 4-3 Чойр хотын одоогийн байдал*



*Эх сурвалж: “Сонголт дизайн” ХХК-ны талбайн судалгаа /2023.08.29-30/*

## **4.2 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ**

Чойр хот нь одоогийн байдлаар нийт хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлт 544.42 га, нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгжүүлэлт 54.31 га, тусгай зориулалттай цэцэрлэгжүүлэлт 0.0 га-д байгуулсан байна. Мөн албан байгууллага, аж ахуй нэгжүүд, айл өрхүүд хашаандаа мод тарьж заншиж байна.

Зураг 4-4 Чойр хотын ногоон байгууламжийн одоогийн байдал



Эх сурвалж: <https://urban.gov.mn/map#/map>

Зураг 4-5 Чойр хотын ногоон байгууламжийн одоогийн байдал



Эх сурвалж: “Сонголт дизайн” ХХК-ны талбайн судалгаа /2023.08.29-30/

Зураг 4-6 Чойр хотын ногоон байгууламжийн одоогийн байдал



Эх сурвалж: “Сонголт дизайн” ХХК-ны талбайн судалгаа /2023.08.29-30/

### 4.3 НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГАЖИЛТИЙН ОДООГИЙН БАЙДАЛ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА

1993 оноос Чойр хотын судалгаа арга зүй төв нэртэйгээр шинэчлэгдэн, 1995 оноос боловсрол төв, 2003 оноос боловсролын, соёлын газар, 2013 оноос Боловсролын газар, 2015 оны 02 сарын 04 өдрөөс Боловсрол, соёлын газар, 2016 оны 09 сарын 12 сараас Боловсрол, соёл, урлагийн газар болж болон ажиллагаагаа явуулж байсан бол 2022 оны 01-р сарын 01-с Соёлын Яам байгуулагдаж Боловсрол Шинжлэх ухааны газар болон үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт аймгийн хэмжээнд 5-н Ерөнхий боловсролын сургууль, 6-н цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байна. Сүмбэр сумын хэмжээнд 3-н ерөнхий боловсролын сургууль, 4-н цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байна. Мөн Уул уурхайн Политехникийн коллеж боловсролын үйл ажиллагаа үзүүлж байна.

#### ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Хүснэгт 4-1 Боловсролын байгууллагын ашиглалтын тодорхойлолт

№	Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Хүчин чадал	Одоо байгаа	Барилга ашиглалт	Нормоор шаардагдах	Эхний ээлж /2025 он/	Төлөвлөлтийн хугацаанд
1	Ерөнхий боловсролын 1 сургууль	Сурагч	640	1154	180.31			
2	Ерөнхий боловсролын 2 сургууль	Сурагч	640	847	132.34			

<b>3</b>	Ерөнхий боловсролын 5 сургууль	Сурагч	640	1315	205.47			
	Нийт		1920	3316	172.71	3074	3693	4400
<b>4</b>	Ерөнхий боловсролын 1 сургууль	Сурагч	320	*	Төсөл		320	
<b>5</b>	Ерөнхий боловсролын 5 сургууль	Сурагч	320	*	Төсөл		320	

*Зураг 4-7 1-р Сургууль*



*Зураг 4-8 2-р Сургууль*



Зураг 4-9 5-р Сургууль



## ЦЭЦЭРЛЭГ

Тус сумын хүүхдийн цэцэрлэг нь анх 1993 онд ашиглалтанд орж байсан одоогийн байдлаар 1,2,5,6 цэцэрлэг 4 барилгад сургуулийн өмнөх насны боловсролын үйлчилгээг үзүүлж байна.. Цэцэрлэгийн байгууламжууд нь гадна тоглоомын талбайтай нарны гэрэл сайн авдаг, аливаа барилга байгууламж халхлаагуугүй байна. Цэцэрлэгийн үйлчлэх хүрээ нь сумын төвийн гэр сууцны хороололд хүртээмжгүй байна. Мөн шинэ суурьшлийн бүс болон Төмөр замын баруун талын айл өрхүүдэд үйлчлэх боломж хомс байна.

№	Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Хүчин чадал	Одоо байгаа	Барилга ашиглалт	Нормоор шаардагдах	Эхний ээлж /2025 он/	Төлөвлөлтийн хугацаанд /2030 он/
1	Сургуулийн өмнөх насны байгууллага 1-р цэцэрлэг	Хүүхэд	175	304	173.71			
2	Сургуулийн өмнөх насны байгууллага 2-р цэцэрлэг	Хүүхэд	140	222	158.57			
3	Сургуулийн өмнөх насны байгууллага 5-р цэцэрлэг	Хүүхэд	250	374	149.6			
4	Сургуулийн өмнөх насны байгууллага 6-р цэцэрлэг	Хүүхэд	100	241	241			
<b>Нийт</b>			565	900	159.29	1054	1407	1886
5	Сургуулийн өмнөх насны байгууллага 5-р цэцэрлэг	Хүүхэд	150*2	*	*		300	*
6	Сургуулийн өмнөх насны байгууллага *-р цэцэрлэг	Хүүхэд	120	*	*		120	*

Зураг 4-10 1-р Цэцэрлэгийн барилга



Зураг 4-11 2- Цэцэрлэгийн барилга



Зураг 4-12 Цэцэрлэгийн барилга







Зураг 4-13 Сансар цэцэрлэг



## ПОЛИТЕКНИК КОЛЛЕЖ

2007 оноос үйл ажиллагаа явуулж байна. Тус коллеж нь 2022 оны байдлаар 18 мэргэжил олгож байна. Коллаж нь үндсэн барилгатай дотуур байртай 8 лаборатори анги танхимгаар үйл ажиллагаа явуулж байна.

№	Барилгын нэр	Хүчин чадал	Хүний тоо	Давхарын тоо	Эхний ээлж /2025 он/	Төлөвлөлтийн хугацаанд /2030 он/
1	Хичээлийн байр-1	*	Гол байр	2	*	*
2	Хичээлийн байр-2	*	Туслах байр	2	*	*
3	Хичээлийн байр-3	*	Спорт заал	2	*	*
4	Дотуур байр	300	*	1	*	*



## ЭМНЭЛЭГ

Нэгдсэн эмнэлгийн анхны тулгын чулууг 1927 онд Төв аймгийн Говьсүмбэр сумын /тухайн үеийн засаг захиргааны нэгжийн хуваариар/ Баруун-Өвөр гэдэг газарт /одоогийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 4-р багийн нутаг/ 1 бага эмчтэйгээр, 2 гэртэй тавьж байсан.

1969 онд Дорноговь аймгийн Сүмбэрийн сангийн аж ахуй байгуулагдахад 15 ортой хүний их эмчийн салбар болон өргөжиж, 12 орон тоотой ажиллаж эхэлсэн.

1991 оны 6-р сарын 21-ний Улсын бага хурлын 46-р тогтоолоор Чойр хот байгуулагдан 1992 онд 40 орон тоотой, 30 ортой нэгдсэн эмнэлэг баригдан ашиглалтад орж нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээг үзүүлж эхэлсэн ба 1994 онд Говьсүмбэр аймаг байгуулагдаж нэгдсэн эмнэлэг нь 89 орон тоотой, 70 ортой болж өргөжин хүн амд 2-р шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байсан.

2021 онд Говьсүмбэр аймагт 100 ортой шинэ эмнэлэг ашиглалтад орж, тус аймагтай хиллэдэг дөрвөн аймгийн 10 гаруй сумын иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авч

эхлээд байна. Учир нь Говьсүмбэр аймагтай хиллэдэг бусад аймаг, сумдын иргэд Говьсүмбэрт хүүхдээ сургах, бизнес эрхлэх, шилжин суурьших тохиолдол элбэг байна.

№	Барилгын нэр	Хүчин чадал	Хүний тоо	Ашиглалтанд орсон он	Давхарын тоо
1	Эмнэлэг	100	-	2021	4
2	Хуучин эмнэлэг	70	-	-	2
3	Эмнэлэг	15	-	-	2
4	Эмнэлэг /Чойр клиник/	-	-	-	2

Зураг 4-14 Эмнэлгийн барилга /Нэгдсэн эмнэлэг/



Зураг 4-15 Эмнэлгийн барилга /Хуучин/





## СОЁЛЫН ТӨВ

“Боржигин” чуулгын шинэ барилга нийт 400 хүнийг нэг дор хүлээн авах хүчин чадалтай бөгөөд барилга ашиглалтад орсноор үзэгчид стандарт шаардлага хангасан танхимд урлаг соёлын үйлчилгээ авахаас гадна уран бүтээлчид зориулалтын өрөө, тасалгаа, танхимд уран бүтээлээ туурвих боломж бүрдэх аж.

*Хүснэгт 4-2 Соёл урлагын барилгуудын ашиглалтын тодорхойлолт*

№	Барилгын нэр	Хүчин чадал	Хүний тоо	Давхарын тоо	Тайлбар
1	Боржигон чуулга	400	-	3	Баригдаж байгаа
2	Боржигон чуулга /хуучин/	200	-	2	
3	Чуулга		-	2	
4	Хийд		-	1	

Зураг 4-16 Боржигин чуулга



Зураг 4-17 Хуучин соёлын төвийн барилга



## ХИЙД

Түшээт гүн Соном ваанчигийн үед түүний хошууны түшмэл тоть Галдаа, Хансан занги, лам Лодоншарав нар Хар бутан дэнж гэж одоогийн сумын төв байрлаж байгаа газарт сүм дуган байгуулахыг зөвшилцаж хамгийн түрүүнд Ганжуур, Данжуур суврага босгосноор энэ хийдийг барих ажил 1810 онд эхэлсэн гэж үздэг. Хожим XIII Далай лам Түвдэнжамц 1904 онд морилж үдэлсний учир Угтаал сангийн далай хэмээн нэрлэх болжээ. Богд эзний жавтай, Цонид чойр бүхий шашны томоохон хүрээ хийдийн нэг юм. Арав гаруй сүм дугантай байсны отгон нь одоогийн Их цогчин Дамбадаржаалин дуган юм. Хийдийн хурлыг голцуу цорж лам, голлон хуруулж 10 мөр суудалд лам нар эгнэн суудаг, тэднээс эрдэм номын цол хамгаалах дамжаа барих хурал хурах үед 600 орчим лам хурдаг байжээ. Энэ хийдийг хаасны дараа тэр бойпирыг Халтарын Жадамбаа гэдэг лам Улаанбаатарт аваачиж Гандантэгчилэн хийдийн Очирдарын сүмийн үүдэнд тавьсан нь одоо байгаа. Энэ хийд нь дөрвөн аймаг, дөрвөн дацантай 300 гаруй ламтай бүрэн хэмжээний цам майдартай 10 гаруй дуган суврагатай

байжээ. Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор энэ дуганыг улсын тусгай хамгаалалтанд авсан. Сангийн далай хийд нь цэцэрлэгжүүлэлт сайтай.

*Зураг 4-18 Сангийн далай хийд*



## **ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Засаг даргын тамгын барилга 1982 онд ашиглалтанд орсон блок, тоосгон хийцтэй барилга.

*Зураг 4-19 Аймгийн тамгын газрын барилга*



Зураг 4-20 Сумын тамгын газрын барилга



#### 4.4 ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Говьсүмбэр аймгийн Чойр хотын төвийн газар ашиглалтын одоогийн байдлын судалгааг байрзүйн зураглал, ГЗБГЗЗГ-с ирүүлсэн мэдээлэл болон тус сумын газрын даамлын кадастрын мэдээллийг үндэслэн боловсруулав. Газар ашиглалтын зураглалын ажлыг Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж (Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль-н 7-р зүйл, Газрын тухай хууль-н 29-р зүйл), геодези, байр зүйн зураглалын норматив баримт бичгийн хүрээнд суурь судалгаа, хээрийн хэмжилт, суурин боловсруулалт, үнэлгээний үе шатыг хамруулан гүйцэтгэсэн болно.

Чойр хотын төвд одоогийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын эзэмшилд нийт 3394 ш нэгж талбар байна. Мөн гэр сууцны зориулалтаар нийт 284.96 га талбайд 2710 ш нэгж талбар бүртгэлтэй байна. Сумын төв нь цөөн хүн амтай боловч эдэлбэр газрынхаа байгаль газар зүйн онцлог, ландшафтаас хамаарч таруу суурьшсан. Мөн сумын төвийн барилгажсан хэсэг нь газар ашиглалтын хувьд гудамж хоорондын зай ихтэй, гэр хорооллын байршил болон гудамж эмх цэгцгүй, шороон зам зүг бүр салбарлаж хөрсийг доройтуулсан байдалтай байна. /ГЗБ-01 зургийг үзнэ үү./

Хот байгуулалтын тухай хуулийн 13-р зүйлд тусгагдсан Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэл-ээр ангилсныг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 4-3 Газрын нэгдмэл сангийн ангилалаар


№	Газар ашиглалтын бүсчлэл	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь			
1	Хөдөө аж ахуйн газар	Тариалан	2.86	8.25	0.07	0.2
2		ХАА-н барилга, байгууламж	5.39		0.12	
3	Хот, тосгон бусад суурины газар	Барилга, байгууламжийн газар	191.96	709.35	4.45	16.43
4		Суурьшлын газар	328.61		7.61	

5		Үйлдвэрийн газар	187.29		4.34	
6		Нийтийн эдэлбэрийн газар	1.49		0.03	
7	Зам, шугам сүлжээний газар	Төмөр замын газар	117.36	221.84	2.72	5.14
8		Авто замын газар	10.2		0.24	
9		Шугам сүлжээний газар	94.28		2.18	
10	Ойн сан бүхий газар	-	-		-	-
11	Усан сан бүхий газар	-	-		-	-
12	Улсын тусгай хэрэгцээний газар	-	0.51	0.51	0.01	0.01
13	Эзэмшил ашиглалтад олгогдоогүй сул чөлөөтэй газар		3376.1	3376.1	78.22	78.22
НИЙТ ДҮН			4316		100	

Мэдээллийн санд бүртгэлтэй нийт 3394 нэгж талбар байгаа бөгөөд үүнээс газар ашиглалтын байдлаар тариалангийн газарт 4 нэгж талбар 2.86 га, ХАА-н барилга, байгууламж 13 нэгж талбар 5.39 га, барилга байгууламжийн газарт 538 нэгж талбар 191.96 га, суурьшлын газарт 2717 нэгж талбар 328.61 га, үйлдвэрийн газарт 41 нэгж талбар 187.29 нийтийн эдэлбэрийн газарт 4 нэгж талбар 1.49, төмөр замын газарт 14 нэгж талбар 117.36 га, авто замын газар 10.2 га, шугам сүлжээний газар 62 нэгж талбарын 94.28 га, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилтын газарт 1 нэгж талбар 0.51 га, сул газар 3376.1 га талбайг тус тус эзэлж байна.



Зураг 4-21 Газар ашиглалт судалгаа, талбайн баланс



Эх сурвалж: “Сонголт Дизайн” ХХК

Хүснэгт 4-4 Чойр хотын газар ашиглалтын одоогийн байдал, талбайн баланс /Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал/

Газар ашиглалтын одоогийн байдал /талбайн баланс/							
ГНС-ын ангилал	Газрын ангилал	Газар ашиглалтын код /Lcode3/	Объектын нэр	Нэгж талбар	Талбай /га/	Эзлэх хувь	Эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	Усалгаатай тариалан	1301	Үр тариа	2	0.27	0.01	0.19
		1302	Төмс, хүнсний ногоо	1	0.59	0.01	
	Усалгаагүй тариалан	1401	Үр тариа	1	2.0	0.05	
	ХАА-н барилга, байгууламжийн газар	1601	Өвөлжөө, хаваржаа	1	0.07	0.00	

		1604	ХАА-н машин, механизмын хашаа, гараж	1	0.82	0.02				
		1606	ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	11	4.5	0.1				
Хот, тосон, бусад суурины газар	Барилга, байгууламжийн газар	2101	Төрийн захиргааны байгууллага	71	62.71	1.45	4.46			
		2103	Урлаг соёлын байгууллага	2	0.22	0.01				
		2104	Боловсролын байгууллага	13	11.05	0.26				
		2105	Эрүүл мэндийн байгууллага	4	4.32	0.1				
		2106	Банк, санхүүгийн байгууллага	2	0.24	0.01				
		2107	Биеийн тамир, спортын байгууллага	1	8.16	0.19				
		2108	Нам, олон нийтийн байгууллага	2	0.35	0.01				
		2110	Зочид буудлын цогцолбор	3	0.6	0.01				
		2111	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, цогцолбор	114	12.52	0.29				
		2112	Дэд бүтцийн байгууллага	2	4.02	0.09				
		2115	Авто машины засвар үйлчилгээний цэг	2	0.65	0.02				
		2116	Авто машины гараж	276	0.91	0.02				
		2117	Шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах, ШТС	39	85.96	1.99				
		2118	Ус түгээх цэг	7	0.25	0.01				
		Зам, шугам сүлжээний газар	Суурьшлын газар	2202	5-8 давхар нийтийн орон сууц	5		3.02	0.07	7.62
				2203	4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	1		5.55	0.13	
				2204	Амины орон сууц	1		0.67	0.02	
				2205	Гэр, орон сууцны хашааны газар	2710		319.37	7.4	
Зам, шугам сүлжээний газар	Үйлдвэрийн газар	2301	Үйлдвэрийн албан контор	5	5.19	0.12	4.34			
		2302	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	36	182.1	4.22				
	Нийтийн эдэлбэрийн газар	2402	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбай	3	0.38	0.01	0.04			

		2403	Цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	1	1.11	0.03	
	Төмөр замын газар	3102	Хамгаалалтын зурвас	10	115.75	2.68	2.72
		3103	Галт тэрэгний өртөө, зөрлөгийн барилга байгууламж	4	1.61	0.04	
	Авто замын газар	-	Хатуу хучилттай авто зам	-	10.2	0.24	0.24
	Шугам сүлжээний газар	3401	Газар дээрх дулаан дамжуулах хоолой	6	2.48	0.06	2.2
		3402	Эрчим хүч, дамжуулах шугам, станц	14	5.57	0.13	
		3409	Цэвэрлэх байгууламж	1	7.3	0.17	
		3410	Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	22	55.49	1.29	
		3411	Холбоо, мэдээлэл дамжуулах шугам	18	20.94	0.49	
		3412	Ус хангамжийн барилга, байгууламж	1	2.5	0.06	
Улсын тусгай хэрэгцээний газар		6501	ШУ, технологийн сорилт, туршилт	1	0.51	0.01	0.01
		2406	Сул чөлөөтэй газар	-	3376.1	78.22	78.22
Нийт				3394ш	4316га	100	100


## ГАЗРЫН ЭРХИЙН ТӨРӨЛ

Чойр хотын төвд 3394 ш нэгж талбар харьяалагдаж байна. Түүнчлэн кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй нийт нэгж талбарууд нь газрын эрхийн төрлийн хувьд 2240 нь газар өмчлөх, 1103 нь газар эзэмших, үлдсэн 51 нь газар ашиглах байна.

Өмчлөх эрхийн бүртгэлтэй нэгж талбарууд нь нийт нэгж талбарын 66.0 хувь буюу 2240 нь 284.96 га талбайг хамарч байна.

Эзэмших эрхийн бүртгэлтэй нэгж талбарын 1103 нь 691.63 га талбай нь нийт нэгж талбарын 32.5 хувийг эзэлж байна.


График 4-1 Газрын эрхийн төрөл



Хүснэгт 4-5 Газрын эрхийн төрөл

№	Газрын эрхийн төрөл	Нийт		
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь /%/
1	Газар өмчлөх	2240	284.96	66.0
2	Газар эзэмших	1103	691.63	32.5
3	Газар ашиглах	51	713.68	1.5
<b>Нийт</b>		<b>3394</b>	<b>1690.27</b>	<b>100</b>

Зураг 4-22 Газрын эрхийн төрөл




### ГАЗРЫН НЭГЖ ТАЛБАРЫН ХЭМЖЭЭ

Чойр хотын төвийн тэг гортиг дэх нийт нэгж талбарыг талбайн хэмжээгээр нь 7 ангилж, эрхийн бүртгэлээр ангилан үзэхэд нийт эдэлбэр газрын 37.3% буюу 1268 нь 1 м<sup>2</sup>-750 м<sup>2</sup>, 9.75% буюу 331 нь 751 м<sup>2</sup>-1000 м<sup>2</sup>, 45.85% буюу 1556 нь 1001 м<sup>2</sup>-2000 м<sup>2</sup>, 2.15% буюу 73 нь 2001 м<sup>2</sup>-3000 м<sup>2</sup>, 0.53% буюу 18 нь 3001 м<sup>2</sup>-4000 м<sup>2</sup>, 0.53% буюу 18 нь 4001 м<sup>2</sup>-5000 м<sup>2</sup>, 3.83% буюу 130 нь 5001 м<sup>2</sup> дээш хэмжээтэйгээр газар олголт хийжээ.


Хүснэгт 4-6 Нийт эдэлбэр газрын хэмжээ

№	Эдэлбэр газрын хэмжээ	Нийт		
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь /%/
1	1м <sup>2</sup> -750 м <sup>2</sup>	1268	48.29	37.36
2	751м <sup>2</sup> -1000 м <sup>2</sup>	331	29.73	9.75
3	1001м <sup>2</sup> -2000 м <sup>2</sup>	1556	240.56	45.85
4	2001м <sup>2</sup> -3000 м <sup>2</sup>	73	17.92	2.15
5	3001 м <sup>2</sup> -4000 м <sup>2</sup>	18	6.3	0.53
6	4001 м <sup>2</sup> -5000	18	8.5	0.53
7	5000 м <sup>2</sup> дээш	130	1338.97	3.83
<b>Нийт</b>		<b>3394</b>	<b>1690.27</b>	<b>100</b>


График 4-2 Газрын талбайн хэмжээгээр



Зураг 4-23 Эдэлбэр газрын хэмжээ



Зураг 4-24 Чойр хотын кадастрын зураг




Эх сурвалж: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, 2022 он

#### 4.5 ГУДАМЖ, ЗАМ, ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭНИЙ ОДООГИЙН БАЙДАЛ

**Гадна зам, тээврийн схем:** Улаанбаатар хотоос Чойр хот хүртэл босоо тэнхлэгийн улсын чанартай 240 км хатуу хучилттай замаар холбогддог. Олон улсын транзит төмөр замын сүлжээгээр холбогдсон тааламжтай нөхцөлтэй юм.

Зураг 4-25 Гадна зам, тээвэр болон гудамж, замын одоогийн байдал



Эх сурвалж: <https://urban.gov.mn/map#/map>

**Гудамж, зам сүлжээ:** Авто замын сүлжээний ихэнх хувийг хатуу хучилттай зам эзэлдэг. Төмөр замын өртөөний жижиг сууцны хороолол, гэр сууцны хороолол дотор шороон замтай байгаа нь орчны тоосжилтыг үүсгэхээс гадна гэр сууцны хорооллын төлөвлөлтгүй газар олголтын улмаас онцгой байдлын үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй байна. Бусад багуудтайгаа Чойр хот сайжруулсан болон хөрсөн замаар холбогдоно.

Зураг 4-26 Гадна зам, тээвэр болон гудамж, замын одоогийн байдал




Эх сурвалж: “Сонголт дизайн” ХХК-ны талбайн судалгаа /2023.08.29-30/

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Хүснэгт 4-7 Говьсүмбэр аймгийн тээврийн хэрэгсэлийн тоо, төрлөөр


Төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Автобус	89	74	67	38	47	58	53
Ачаа	545	523	499	607	577	619	547
Суудал	1,573	1,673	1,686	1,639	1,685	2,001	1,927
Тусгай	62	63	59	54	58	75	80
Нийт	2,269	2,333	2,311	2,338	2,367	2,753	2,607





Хүснэгт 4-8 Чойр хотын тээврийн хэрэгсэлийн тоо, төрлөөр

Төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Автобус	64	53	47	29	38	50	46
Ачаа	420	417	396	459	446	485	420
Суудал	1,226	1,285	1,312	1,248	1,283	1,543	1,464
Тусгай	54	55	53	47	49	62	68
Нийт	1,764	1,810	1,808	1,783	1,816	2,140	1,998



## 5 ТАВДУГААР БҮЛЭГ. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

“Говьсүмбэр аймгийн Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлын хүрээнд дулаан хангамжийн системийн одоогийн байдал, төлөвлөлтийг дараах баримт бичгийг үндэслэн боловсруулав.

Үүнд:

1. Говьсүмбэр аймгийн Засаг дарга Г.Батсуурь 2023 оны 00-р сарын 00-ны өдөр баталсан Дугаар: ХЕТ-00000/2023 “Говьсүмбэр аймгийн Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар”;
2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” /2.5.3. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэн 2050 он гэхэд бүх төрлийн орон сууцыг инженерийн шугам сүлжээтэй болгоно;
3. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын /4.7.2г, 4.7.3, 4.7.5 б, 5.1.3 дахь заалтууд;
4. Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт;
5. Говьсүмбэр аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-8.1.6, 8.1.8;
6. Говьсүмбэр аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-Зорилго-6. Ногоон хөгжил;
7. Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт-3.5 Эрчим хүчний найдвартай байдлыг хангах.-3.5.2-3.5.3-заалт;
8. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 3.7.5 Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө;
9. Газар зохион байгуулалт “Газрын тухай хуулийн 24.1” ;
10. Архитектор орон зайн төлөвлөлтийн шийдэл;

### 5.1 ДУЛААН ХАНГАМЖИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

Чойр хот нь Улаанбаатар хотоос 230 км зайтай. 2022 оны хүн амын статистикийн судалгааны байдлаар Говьсүмбэр аймгийн хэмжээнд 5265 өрхийн 18042 хүн суурьшиж байна. Аймгийн хэмжээнд Баянтал, Шивээговь болон Сүмбэр гэсэн 3 сумтай. Чойр хотын төвийг Сүмбэр гэх бөгөөд 6 багтай. Сумын төвд Сансар, Ганзам, Найрамдал гэж хуваагддаг. Сумын хэмжээнд 3848 өрхийн 13176 хүн суурьшиж байна.

Говьсүмбэр аймгийн Чойр хот нь Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНБД 23-01-09/-ийн хүснэгт 5-д заасны дагуу уур амьсгалын II-р бүсэд байрладаг.

Гадна агаарын тооцооны температур:

Хамгийн хүйтэн үеийн 1 хоногийн температур

-33.2°C

Хамгийн хүйтэн 3 хоногийн температур	-31.9°C
Хамгийн хүйтэн 5 хоногийн температур	-30.7°C
Хамгийн халуун үеийн 1 хоногийн температур	°C

Галлагааны хугацаа эхлэх өдөр 15.IX , дуусах өдөр 15.V , үргэлжлэх хоног 245 өдөр.

*Зураг 5-1 Чойр хотын орчны тойм*



Одоогоор Чойр хотын хэмжээнд 8ш халаалтын зуухнаас хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангаж байна. Тус халаалтын зуухнуудын шугам сүлжээ болон зуухны ашиглалт үйл ажиллагааг хувийн хэвшлийн болон орон нутгийн байгууллагууд хариуцан ажиллаж байна. Эдгээрээс Төмөр замын харьяа 4ш зуухны барилга, Хонхор, Сүмбэр, Шүүхийн болон Хорихын гэсэн зуухнаас хэрэгцээний халуун ус болон дулааны эрчим хүчийг түгээж байна.

Зураг 5-2 Чойр хотын эх үүсвэрийн байрлал болон дулааны шугамын одоогийн байдал



## 1-Р БАГ ГАН ЗАМ ХЭСЭГ

### Төмөр замын I зуух

I халаалтын зуухны газар нь төмөр замын төв зуухны үүргийг гүйцэтгэдэг бөгөөд 45 орон сууц, 23 албан газрын барилга байгууламжийн Q-3.13 Гкал/ц дулааны эрчим хүчээр ханган ажиллаж байна. Хэрэглэгчдийн дулааны ачаалал, шугамын урт диаметр болон зуухны мэдээллийг хүснэгтээр оруулав.

Хүснэгт 1. Одоо байгаа барилгын дулааны ачаалал

№	Барилгын нэр	Давхар	Талбай, м2	Эзэлхүүн, м3	Тоо, ш	Хүчин чадал /хүн/	Дулааны ачаалал, кВт		Нийт
							Халаалт	Халуун ус	
							БНБД 41-02-05		
<b>23-р хэсэг</b>									
1	ЧойрМРЦ	3	275	2475	1		80.6	0	80.62
2	Техникийн үзлэгийн газар	1	361	1083	1		35.3	0	35.28

3	Зэхэлий /ус/	1	47	141	1		4.6	0	4.59
4	Уурын зуухны газар	1	282	846	1		0	0	0
5	Зоорь		4556	0	2		0	0	0
6	Амрах байр	2	459	2754	1	20	89.7	0	89.71
7	Алтан нутаг /зочид буудал/	1	285	855	1	10	27.9	0	27.85
8	Тоосгон сууц №130	1	167	501	1	10	16.3	8.03	24.34
9	2 давхар сууц	2	486	2916	6	48	569.9	231.12	801.03
10	5 давхар сууц №133	5	486	7290	1	120	199.5	96.3	295.76
<b>23-р хэсгийн нийлбэр ачаалал</b>							<b>1023.7</b>	<b>335.45</b>	<b>1359.17</b>
<b>26-р хэсэг.Б</b>									
11	2 айлын модон сууц	1	133	399	1	8	13	6.42	19.42
12	1 айлын модон сууц	1	69	207	1	4	6.7	3.21	9.95
13	Авто засварын газар	1	80	240	1		7.8	0	7.82
14	Талхны үйлдвэр	1	200	600	1	0	19.5	0	19.54
15	1 айлын тоосгон сууц	1	140	420	1	4	13.7	3.21	16.89
16	2 айлын тоосгон сууц	1	170	510	1	8	16.6	6.42	23.03
17	2 айлын модон сууц	1	101	303	1	8	9.9	6.42	16.29
18	1 айлын модон сууц	1	76	228	1	4	7.4	3.21	10.64
19	2 айлын модон сууц	1	100	300	1	8	9.8	6.42	16.19
20	Халуун ус	1	355	1065	1	10	34.7	8.37	43.06
<b>26Б-р хэсгийн нийлбэр ачаалал</b>							<b>139.2</b>	<b>43.68</b>	<b>182.84</b>
<b>27-р хэсэг</b>									
21	2 айлын тоосгон сууц №18	1	104	312	1	8	10.2	6.42	16.58
22	2 айлын тоосгон сууц №19	1	104	312	1	8	10.2	6.42	16.58
23	2 айлын тоосгон сууц №20	1	104	312	1	8	10.2	6.42	16.58

24	2 айлын тоосгон сууц №21	1	104	312	1	8	10.2	6.42	16.58
25	2 айлын тоосгон сууц №22	1	116	348	1	8	11.3	6.42	17.76
26	2 айлын модон сууц №23	1	122	366	1	8	11.9	6.42	18.34
27	2 давхар сууц №117	2	423	2538	1	8	82.7	6.42	89.09
28	2 айлын тоосгон сууц №24	1	178	534	1	8	17.4	6.42	23.81
29	2 айлын тоосгон сууц №25	1	160	480	1	8	15.6	6.42	22.06
30	ТХҮҮ-н контор	1	241	723	1		23.6	0	23.55
31	Ган зам дэлгүүр	1	354	1062	1		34.6	0	34.59
32	Талс барилгын материалын дэлгүүр	1	243	729	1		23.7	0	23.75
33	Модон дэлгүүр	1	170	510	1		16.6	0	16.61
34	Тоосгон байр	1	117	351	1	4	11.4	0	11.43
35	Модон сууц	1	275	825	1	4	26.9	3.21	30.08
36	Модон сууц	1	275	825	1	4	26.9	3.21	30.08
37	Дэлгүүр тоосгон	1	86	258	1		8.4	0	8.4
38	Дэлгүүр тоосгон	1	181	543	1		17.7	0	17.69
39	Блокон сууц	1	36	108	1	4	3.5	3.21	6.73
40	Дэлгүүр тоосгон	1	232	696	1		22.7	0	22.67
41	Модон сууц	1	92	276	1	4	9	3.21	12.2
42	Сансар цэцэрлэг	2	600	3600	1	150	117.3	36.64	153.9
<b>27-р хэсгийн нийлбэр ачаалал</b>							<b>521.8</b>	<b>107.26</b>	<b>629.08</b>
<b>30-р хэсэг</b>									
43	2-р сургууль	2	695	4170	1		135.8	0	135.83
44	Спорт заал	2	431	2586	1	150	84.2	125.61	209.84
45	2-р сургуулийн өргөтгөл	2	634	3804	1		123.9	0	123.91
46	Модон сууц	1	164	492	1	120	16	96.3	112.33

47	2 айлын тоосгон сууц №15	1	135	405	1	8	13.2	6.42	19.61
48	2 айлын тоосгон сууц №14	1	135	405	1	8	13.2	6.42	19.61
49	2 айлын тоосгон сууц №13	1	135	405	1	8	13.2	6.42	19.61
50	2 айлын тоосгон сууц №12	1	100	300	1	8	9.8	6.42	16.19
51	Модон сууц	1	513	1539	1	4	50.1	3.21	53.34
52	Модон сууц	1	500	1500	1	4	48.9	3.21	52.07
53	Тоосгон сууц №20	1	276	828	1	4	27	3.21	30.18
54	Тоосгон сууц №19	1	270	810	1	4	26.4	3.21	29.59
55	Тоосгон сууц	1	110	330	1	4	10.7	3.21	13.96
56	Тоосгон сууц №95	2	296	1776	1	4	57.9	3.21	61.06
57	Тоосгон сууц №96	2	296	1776	1	4	57.9	3.21	61.06
<b>30-р хэсгийн нийлбэр ачаалал</b>							<b>688.1</b>	<b>270.06</b>	<b>958.2</b>
<b>Зуухны дулааны нийт ачаалал</b>							<b>2372.8</b>	<b>756.5</b>	<b>3129.3</b>
<b>Сүлжээний усны зарцуулалт, т/цаг</b>									<b>59.8</b>

*Хүснэгт 2. ТЗ-н 1-р зуухны шугамын диаметр болон урт*

№	Халаалт		Хэрэгцээний халуун ус	
	Шугамын диаметр, мм	Шугамын урт, м	Шугамын диаметр	Шугамын урт, м
1	2Ф200	396		
2	2Ф150	348		
3	2Ф125	356		
4	2Ф100	286		
5	2Ф80	60	2Ф80	643
6	2Ф70	537	2Ф70	75
7	2Ф50	843	2Ф50	390
8	2Ф40	169	2Ф40	237
9	2Ф32	333	2Ф32	382

10	2Ф25		2Ф25	49
11	2Ф20		2Ф20	199
12	2Ф	1755	2Ф	544
Нийт		5083		2519

Хүснэгт 3. ТЗ-н 1-р зуухны тоног төхөөрөмжийн үзүүлэлт

№	Ангилал	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Хүчин чадал, Гкал/ц
1	Халаалт	Усан халаалтын тогоо	БЗУИ-100	0.7
2		Усан халаалтын тогоо	БЗУИ-100	0.7
3		Усан халаалтын тогоо	КВР-1.5	0.7
4		Усан халаалтын тогоо	ТЗҮ-1.5	0.7
5		Усан халаалтын тогоо	ТЗҮ-1.5	0.7
<b>Нийт хүчин чадал</b>				<b>3.5</b>
6	Хэрэглээний	Усан халаалтын тогоо	НР-18/54	0.35
<b>Нийт хүчин чадал</b>				<b>0.35</b>



### Төмөр замын II зуух

II-р халаалтын зуухнаас 12 орон сууц, 17 албан газрын барилга байгууламжийн Q-3.13 Гкал/ц дулааны эрчим хүчээр ханган ажиллаж байна. Хэрэглэгчдийн дулааны ачаалал, шугамын урт диаметр болон зуухны мэдээллийг хүснэгтээр оруулав.


Хүснэгт 4. ТЗ-н 2-р зуухны шугамын диаметр болон урт

№	Халаалт	
	Шугамын диаметр, мм	Шугамын урт, м
1	2Ф200	85
2	2Ф125	69
3	2Ф100	112
4	2Ф80	386
5	2Ф70	394
6	2Ф50	457



7	2Ф40	174
8	2Ф32	163
9	2Ф25	71
10	2Ф20	
11	2Ф	
Нийт		1911

*Хүснэгт 5. ТЗ-н 2-р зуухны мэдээлэл*

№	Ангилал	Тоног төхөөрөмжийн нэршил	Марк	Хүчин чадал, Гкал/ц	
1	Халаалт	Усан халаалтын тогоо	НР-18/54	0.35	
2		Усан халаалтын тогоо	НР-18/54	0.35	
3		Усан халаалтын тогоо	КВм-1.63	0.7	
<b>Нийт хүчин чадал</b>				<b>1.4</b>	

### Төмөр замын III зуух


III-р халаалтын зуухнаас 5 орон сууц, 18 албан газрын барилга байгууламжийн дулааны эрчим хүчийг ханган ажиллаж байна.

*Хүснэгт 6. ТЗ-н 3-р зуухны шугамын диаметр болон урт*

№	Халаалт	
	Шугамын диаметр, мм	Шугамын урт, м
1	2Ф125	138
2	2Ф100	142
3	2Ф80	28
4	2Ф70	241
5	2Ф50	249
6	2Ф40	201
7	2Ф32	241
8	2Ф25	6
Нийт		1246

Хүснэгт 7. ТЗ-н 2-р зуухны мэдээлэл

№	Ангилал	Тоног төхөөрөмжийн нэршил	Марк	Хүчин чадал, Гкал
1	Халаалт	Усан халаалтын тогоо	ТЗУ-0.63	0.63
2		Усан халаалтын тогоо	ТЗУ-0.33	0.35
<b>Нийт хүчин чадал</b>				<b>0.98</b>



**2-Р БАГ САНСАР ХЭСЭГ**

Сумын 2-р баг Сансар талд байрлах Сүмбэр халаалтын зуухнаас 34 хэрэглэгчдийн Q-2.85 Гкал/цаг дулааны тооцоот ачаалал бүхий барилга объектын дулааны эрчим хүчийг түгээн ажиллаж байна. Тус зуухны нүүрсийг Ховилын нүүрсний уурхайгаас 70 км зайнаас жилдээ 4500 тн нүүрсийг хангаж ажилладаг.


Хүснэгт 8. Илчит Сансар ХХК дулааны шугам сүлжээнд холбогдсон барилга байгууламжийн дулааны ачаалал

д/д	Барилгын нэр	Эзэлхүүн, м3	Дулааны ачаалал, Ккал/ц	Зарцуулалт, тн/ц
1	Нийгмийн даатгал	2592	45997.632	1.31
2	Боржигон Чуулга	3830	67967.18	1.94
3	Музей	709	12581.914	0.36
4	Өмгөөлөгчдийн зөвлөл	40	709.84	0.02
5	Ахуй үйлчилгээ	423	7506.558	0.21
6	Баясал цэцэрлэг	2332	46110.636	1.32
7	1-р сургууль	10420	160582.62	4.59
8	Нэгдсэн эмнэлэг	38831	590619.51	16.87
9	Номын сан	606	10754.076	0.31
10	Спорт Хороо	5564	85746.804	2.45
11	Дэлгэрэх билэг	2295	40727.07	1.16
12	Их Сансар	868	15403.528	0.44
13	Ахмадын Хороо	585	9015.435	0.26
14	Онцгой байдлын хэлтэс	6752	104055.072	2.97

15	Далай Хишиг	25	443.65	0.01
16	Шүүх шинжилгээний алба	952	14671.272	0.42
17	Цагдаагийн хэлтэс	10040	164103.8	4.69
18	Цаг уур	307	4731.177	0.14
19	Цөм сүрэг	290	4469.19	0.13
20	Шуудан холбоо	689	10618.179	0.30
21	Эрүүл мэндийн газар	2000	40560	1.16
22	Спининг	306	4715.766	0.13
23	Сүмбэр СЗДТГ	2016	40483.296	1.16
24	Цахилгаан Түгээх сүлжээ	4041	81147.321	2.32
25	Байгаль Орчин	1553	31185.793	0.89
26	Айл өрх	-	-	-
Нийт		98066	1594907.32	45.57
Цагдаагий хэсэг				
1	Онцгой байдлын алба	1731	86190.9	2.46
2	ХААН банк	1032	25692.17	0.73
3	Цагдаагийн 40 айл	900	900515.9	25.73
4	Цагдаагийн хэлтэс	2940	73190.02	2.09
5	Спорт заал	2856	71100.6	2.03
6	Шүүхийн шинжилгээний төв	585	29131.6	0.83
7	Хурлын заал	957	47652.6	1.36
8	Тоосгон байр	531	29200.34	0.83
Нийт		11532	1262682.72	36.1

*Хүснэгт 9. Илчит Сансар ХХК зуухны мэдээлэл*

№	Ангилал	Тоног төхөөрөмжийн нэршил	Марк	Тоо, ш	Хүчин чадал, Гкал
1	Халаалт	Усан халаалтын тогоо	ДТХ-0.9	3	0.77

<p><b>Нийт хүчин чадал</b></p>	<p><b>2.32</b></p>	
--------------------------------	--------------------	--

### 3-Р БАГ НАЙРАМДАЛ ХЭСЭГ

Сумын 3-р баг Найрамдал талд байрлах Хонхор халаалтын зуухнаас Ф373-Ф20 мм голчтой дулааны эрчим хүчийг нийт 3353 м урттай шугамаар дамжуулан сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон улсын болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагууд, айл өрхийн 8.6 Гкал/цаг дулааны тооцоот ачаалал бүхий барилга объектын дулааны эрчим хүчийг түгээн ажиллаж байна.

*Хүснэгт 10. Хонхор зууханд холбогдсон хэрэглэгчдийн дулааны ачаалал*

Д/д	Хэрэглэгчийн нэр	Давхарын тоо	Эзлэхүүн	Хувийн дулааны тодорхойлолж	Дулааны ачаалал
			м3	ккал/ц	Гкал/цаг
1	Аймгийн ЗДТГазар	4	6,075	0.5	0.15
2	5-р сургууль	3	11,830	0.5	0.29
3	5-р цэцэрлэг 1	2	7,417	0.5	0.18
4	Усан спортын төв	1	3,148	0.5	0.08
5	ХААН банк	2	1,408	0.5	0.03
6	Оргил буудал	2	327	0.5	0.01
7	Андүүд дэлгүүр	1	962	0.5	0.02
8	Баялаг барилгын материалын дэлгүүр	1	360	0.5	0.01
9	Осо констракшн	1	449	0.5	0.01
10	Ус-Ду ОНӨҮГ Контор,	1	1,155	0.5	0.03
11	Ус-Ду ОНӨҮГ ЗУУХ	1	2,898	0.5	0.07
12	Ус-Ду ОНӨҮГ ГРАЖ	1	827	0.5	0.02

13	1-байр	5	27245	0.5	0.66
14	2-байр	5	27245	0.5	0.66
15	3-байр	5	27245	0.5	0.66
16	4-байр	5	27245	0.5	0.66
17	5-байр	5	14610	0.5	0.36
18	6-байр	5	17003	0.5	0.41
19	7-байр	5	21061	0.5	0.51
20	8-байр	5	17216	0.5	0.42
21	9-байр	5	17216	0.5	0.42
22	10-байр	5	17216	0.5	0.42
23	11-байр	5	17216	0.5	0.42
24	12-байр	5	17216	0.5	0.42
25	15-байр	5	17216	0.5	0.42
26	Буян гого	2	600	0.5	0.01
27	Татвар	2	2030	0.5	0.05
28	Халамж	2	1188	0.5	0.03
29	5-р сургуулийн дотуур байр	2	3340	0.5	0.08
30	МХГ лаборатори	1	630	0.5	0.02
31	МСҮТөв	2	3456	0.5	0.08
32	МСҮТөв - 2	2	9671.8	0.5	0.24
33	МСҮТөв - 3	1	12822.7	0.5	0.31
34	МСҮТөв - 4	1	468	0.5	0.01
35	5-р цэцэрлэг өргөтгөл-2	2	5312.6	0.5	0.13
36	5-р цэцэрлэг өргөтгөл-3	2	5312.6	0.5	0.13
37	шинэ хаус-1	1	352	0.5	0.01
38	шинэ хаус-2	1	352	0.5	0.01
39	шинэ хаус-3	1	352	0.5	0.01
40	шинэ хаус-4	1	580	0.5	0.01
41	Баялаг дэлгүүр	1	360	0.5	0.01

42	прукрор	2	2200	0.5	0.05
43	Арьс ширний үйлдвэр	1	754	0.5	0.02
<b>Нийт</b>			<b>351,588</b>		<b>8.6</b>


*Хүснэгт 11. Шугамын мэдээлэл*

№	Одоо байгаа шугамын диаметр, Фd мм	Шугамын урт, м
1	2ф373 ган	10
2	2ф300 ган	131
3	2ф200 ган	1037
4	2ф150 ган	506
5	2ф100 ган	542
6	2ф80 ган	1472
7	2ф70 ган	244
8	2ф60 ган	48
9	2ф50 ган	171
10	2ф40 ган	75
11	2ф32 ган	72
12	2ф20 ган	35

**Хонхорын зуухны газрын мэдээлэл :** Зуухны барилга 889 м<sup>2</sup> хэмжээтэй. Халаалтын зуухны өгөх буцах усны тооцоот температур 115/70<sup>0</sup> С. Сумын төвөөс зүүн урагш 20 км зайтай Шивээ-Овоо ХК уурхайгаас халаалтын улиралд 8894.6 тн нүүрсийг татан авч ашигладаг.

*Хүснэгт 12. Хонхор зуухны мэдээлэл*

№	Ангилал	Тоног төхөөрөмжийн нэршил	Марк	Тоо , ш	Хүчин чадал , Гкал
1	Халаал	Усан халаалтын тогоо	DZL-7-1625/115-70/All	2	6.02

<p><b>Нийт хүчин чадал</b></p>	<p><b>12.04</b></p>	
--------------------------------	---------------------	---

Хорих анги болон ажилчдын зуух нь бие даасан дулааны эх үүсвэрээр барилгын дулааны ханган ажилладаг. Төмөр замын 4-р зуухны газар нь Зам ангийн засварын депо, ТЗ-ын гражийг дулаанаар ханган ажилладаг.

*Хүснэгт 13. Хорих ангийн хэрэглэгчдийн ачаалал*

№	Барилгын нэр	Давхар	Талбай, м <sup>2</sup>	Эзэлхүүн, м <sup>3</sup>	Тоо, ш	Хүчин чадал /хүн/	Дулааны ачаалал, кВт		Нийт
							Халаалт	Халуун ус	
							БНБД 41-02-05		
1	Хорих ангийн 5 давхар орон сууц	5	978	14670	1	300	401.4	240.75	642.12
2	Дэлгүүр	1	105	315	1		18.2	0	18.24
<b>Нийлбэр ачаалал</b>							<b>419.6</b>	<b>240.75</b>	<b>660.36</b>

**ОДОО БАРИГДАЖ БУЙ 20 ГКАЛ/Ц ХҮЧИН ЧАДАЛТАЙ ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР**

“Мон-Энержи Консалт ХХК”-н төлөвлөж буй дулааны шугам сүлжээний ажлын зураг нь шинээр төлөвлөгдөх Q=20 Гкал/ц хүчин чадалтай дулааны эх үүсвэрээс хангагдана. Дулаан хангамжийн 1-р хэлхээний шугамын дулаан зөөгч ус нь дулааны станцын хэрэглээний стандарт хангасан зөөлрүүлсэн ус байна. Сүлжээний усны хэм 120/70С байхаар тусгагдана.



*Зураг 5-3 Чойр 20 Гкал/ц хүчин чадалтай Дулааны станц баригдаж буй байдал*

Төлөвлөлтийн хүрээнд нийт 5 ш Ус дулаан дамжуулах төв /УДДТ/  $\varnothing 80-350$ мм голчтой 7.1 км орчим дулааны хос шугамыг угсрахаар төлөвлөв. УДДТөв нь халаалт болон хэрэглээний халуун усыг бэлтгэх чадалтай цогц төхөөрөмж бүхий байгууламж байхаар төлөвлөгдсөн.

*Хүснэгт 14. УДДТ-ийн дулааны ачаалал,шугамын урт болон диаметр*


УДДТөв	Халаалтын ачаалал Гкал/ц	Хэрэглээний халуун усны ачаалал Гкал/ц	Нийт дулааны ачаалал Гкал/ц
№	Q <sub>х</sub>	Q <sub>хху</sub>	Q <sub>н</sub>
УДДТ-1 х2	5.28х2	0.72х2	6.0х2
УДДТ-2	3.38	0.46	3.84
УДДТ-3	0.81	0.11	0.92
УДДТ-4	0.45	0.06	0.51
УДДТ-5	2.4	0.33	2.73
Нийт	17.6	2.4	20

*Хүснэгт 15. Шугамын мэдээлэл*

Хоолойн голч	Хос шугамын трассын урт /м/
--------------	-----------------------------



φ80	305
φ125	560
φ150	100
φ200	3155
φ250	2100
φ300	390
φ350	485
Нийт	7095



Зураг 5-4 Дулаан хангамжийн угсралтын тойм байгуулалт

Хүснэгт 16. Дулаан хангамжийн үнэлгээ

Хот, суурины нутаг	Сумын ТӨВИЙН ХОТ	Үзүүлэлтүүд					Хангажийн хувийн ангилал
		Нор	МОО	Одо	а	Ханг	

					Нэн өндөр	Өндөр 75-100%	Дунд 50-75%	Доогуур	Нэн доогуур 25% доош
					Үнэлгээ 5 баллаар				
					5	4	3	2	1
Чойр	44.2	42.8	23.4	54.6%	3				
Үнэлгээний балл					Дунд				

## ДУЛААН ХАНГАМЖИЙН ОДООГИЙН БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Чойр хотын одоогийн дулаан хангамжийн үнэлгээг тооцож үзэхэд 3 балл буюу дулаан хангамжийн хувьд дунд түвшинтэй байна. “10 аймгийн Дулааны Станц”-н төсөл “Мон-Энержи Консалтинг ХХК”-н гүйцэтгэлээр тус 20 Гкал/ц хүчин чадалтай дулааны станцын ажил хэрэгжиж байна. Тус Дулааны станц нь одоогийн байгаа 8ш халаалтын зууханд холбогдсон хэрэглэгчдийн дулааны шаардлагат ачааллыг бүрэн хангах бөгөөд, шинээр төлөвлөж буй 1000 айлын орон сууц болон Үйлдвэрийн нөөц бүсэд баригдах орон сууцны хэсгийн төлөвлөлтийн дулааны ачааллыг хангаж хүрэлцэхгүй тул ирээдүйд өргөтгөх шаардлагатай.

## 5.2 УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ОДООГИЙН БАЙДАЛ

### УС ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

Говьсүмбэр аймгийн сумын сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу, ажлын даалгавар, ГСАОНӨГ/202312015 тоот дугаартай ажил гүйцэтгэх гэрээний холбогдох байгууллагууд болон газар дээр нь хийсэн судалгаа, мөн 2014 онд хийгдсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэргийг үндэслэн усан хангамж, ариутгах татуургын одоогийн байдлын тайланг боловсруулав.

1991 оны 6 сарын 21-ны өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь сум, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хотыг байгуулж мөн оны 7 сарын 25-ны өдрийн 117 дугаар тушаалаар Чойр хотын эрчим хүчний үйлдвэрийг байгуулсан нь одоогийн НААҮ-ний “УС ДУ” ОНӨААТҮГазар юм.

Ус хангамжийн хэсэг нь үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад голлох нөлөөг үзүүлдэг хэсэг юм. Уг хэсэг нь бохир ус татан зайлуулах, цэвэр усаар айл өрх, албан байгууллагуудыг хангах үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Ус хангамжийн хэсэгт усан хангамж,

ариутгах татуургын инженер-1, цэвэр усны оператор-3, сантехникийн слесарь-4, бохирын слесарь-2 нийт 10 ажилтантай ажиллаж байна.

Аймгийн төвийн усан хангамж нь “Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар”-ын Тэрэгтийн газрын доорх цэнгэг усны ордоос ус ашиглаж байна. “Ус-Ду” ХХК нь газрын доорхи усыг олборлон хэрэглэгчдэд эрүүл ахуй стандартад тохирсон цэвэр ус түгээх зорилготой. Аймгийн төвийн Хонхор хотхоны 49 аж ахуйн нэгж, байгууллага, 1200 айл өрхөд дулаан, халуун хүйтэн усаар хангаж, бохир ус татан зайлуулах, сантехникийн засвар хийх зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн онцгой байдлын хэлтэс гал унтраах зориулалтаар, Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар мод услах зориулалтын усыг “Ус-Ду” ХХК байгууллагын зүгээс усаар хангадаг.

**Говьсүмбэр аймаг Сүмбэр сумын газрын доорх усны ай савын геоморфологи, геологи, гидрогеологийн нөхцөл:**

**Геоморфологи:** Чойрын ай сав нь Говьсүмбэр аймгийг эзлэн оршино. Далайн түвшнээс дээш дундажаар 1000-1200 м өргөгдсөн говь тал хээр хосолсон нутаг юм. Говь тал нутагт алсаас бараа нь сүндэрлэн харагдах 1400 м-ээс дээш өндөртэй уул энэ аймгийн нутагт багагүй байдаг. Тухайлбал: Оцол уул (1695.5 м), Их Сансар уул (1682.5 м), Бага Сансар уул (1669.8 м), Чойрын Богд уул (1578.5 м), Сүмбэр уул (1565.4 м), Өндөр улаан уул (1495.6 м), Дулаан хар уул (1481.3 м), Их уул (1444.2 м) юм.

**Геологи:** Чойрын артезийн ай савын геологийн тогтоц нь цэрдийн галавын элсэн чулуу, гравелит, конгломерат бүхий зарим хэсэгтээ нүүрс агуулагч тунамал чулуулгаас голчлон тогтсон. Баруун талаас нь юра цэрдийн хүрмэн чулуу, андезитехүрмэн чулуу бүхий галт уулын бялхмал чулуулаг түрж орж ирсэн байдаг. Хойт талаараа цэрдийн улаан, эрээн өнгөт шаварлаг чулуулаг, саарал өнгөт элс-хайргархаг чулуулгаас бүрдсэн нэгдлүүд үргэлжилнэ. Эдгээр эртний суурь чулуулаг нь орчин үеийн элювийн, элюви-дэлювийн хад чулуурхаг, элс элсэнцэр сэвсгэр хурдсаар бүрхэгдсэн байна.

**Гидрогеологийн нөхцөл:** Чойрын артезийн ай сав нь Төв, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын нутгийн зарим хэсэгт байрласан уулс хоорондын грабен хотгор юм. Энэ сав газрын тэжээмж хуримтлалын дотоод муж нь 2325 км<sup>2</sup>, гадаад муж болох хүрээлэн байгаа уулсын талбай нь 5020 км<sup>2</sup> тус тус байдаг.

Чойр орчмын уулс нь 1300-1650 м өндөр өргөгдсөн, гүвээ толгод, дунд зэргийн уулс юм. Нам газар болох Чойрын хотгорт олон нуур, тойром үүссэн байдаг. Чойрын хотгор нь цэрдийн настай элсэн чулуу, алевролит, хөрзөн чулуу, хүрэн хүүрс, шавар зэрэг 800 м зузаантай хурдсаар дүүргэгдсэн байдаг.

Б.А.Картавин, Н.А.Маринов нар Чойрын артезийн ай савд гидрогеологийн 2 давхар структурыг ялган үзсэн байдаг бөгөөд гидрогеологийн 1 дүгээр структурт тэжээлийн гадаад муж сав

газрыг фундамент, 2 дугаар давхарт тэжээмж, хуримтлал, газрын гадаргад илрэх дотоод мужийг хамааруулан ялгасан байдаг.

Тэжээлийн гадаад мужид протерзойн настай гнейс, кварцит, кристаллаг занар, шохойн чулууны 3000-5000 м зузаан зузаалаг, кембрийн настай хөрзөн чулуу, шохойн чулуу, андезит, порфиритийн 2400-2500 м зузаан зузаалаг, дээд девон доод карбоны настай хөрзөн чулуу, элсэн чулуу, цахиурлаг занар, алевролит, кварцын порфиритын 500 м орчим зузаан зузаалаг, дунд-дээд карбоны болон доод перми, дээд юрагийн настай төрөл бүрийн эффузив чулуулгийн 100-700 м зузаан зузаалаг тус тус тархсан байна.

Палезой, мезозой гранитоидын өгөршлийн ан цав, тектоник хагарлын бүсээр ан цавын ус элбэг тархсан ба энэ үед илэрсэн цооногоор ундарга нь 18-33.4 м бууралтанд 0.1-0.18 л/с, усны чанар найрлагын хувьд гидрокорбанат натрийн цэнгэг ус байх бөгөөд хотгор гүдгэрийн нам газраараа эрдэсжилт ихтэй, (5.6-8.5 г/л) сульфат, хлорид-сульфат-натрийн ус тааралдана.

Протерзой, кембрийн хувирмал чулуулагт газрын доорх ус алаг цоог тархсан байх бөгөөд 1.5 м гүнээс илрэх ба энэ давхаргад илэрсэн худгийн ундарга нь 0.15-0.3 л/с, гидрокарбонат-сульфат, хлорид-гидрокарбонат-натрийн сулавтар шорвог устай.

Дээд девон-доод карбоны хурдсанд 0.3-25 м-ээс ус илрэх ба цооногийн ундарга нь 5.2-7.0 м түвшний бууралтанд 1.7-5 л/с бөгөөд 0.6-0.9 г/л эрдэсжилттэй гидрокарбонат-сульфат, гидрокарбонат-натрийн ус байна.

*Хүснэгт 5-1 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сумын газрын доорх усны ордууд*

д/д	Газрын доорхи усны ордын нэр	Ордын байршил	Нийлбэр нөөц л/с	Ашиглалтын байдал	Ашиглах жил	Усны эрдэсжилт	Хайгуул хийсэн он	Ордын талбай /км <sup>2</sup> /
1	Шивээ-Овоо	ГСА Сүмбэр	166,8	Ашиглаж байгаа	25	0,4-2,8	1991	368,5
2	Тэвшийн хөндий	ГСА Сүмбэр	20,8	Ашиглаж байгаа	25	2,4-3,6	2009	51
3	Тэрэгт	ГСА Сүмбэр	19,0л/с	Ашиглаж байгаа			2018	

